Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

COAL MONGOLIA 2014

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 4 ДЭХ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, УЗЭСГЭЛЭН

2014 оны 2 дугаар сарын 20-21

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

www.coalmongolia.mn +976-70115590

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2014 он. 1 сар. №02 (060) www.mongolianeconomy.mn



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛ ӨНӨӨДӨР МАРГААШ

PC mall®

АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР



Bose® Solo TV sound system

Таны телевизорын дуугаралтыг
төгс болгох хялбар шийдэл

Үнэ: 880.800 төгрөг

Сүхбаатар дүүрэг, Хүнсний 4-р дэлгүүрийн хойд талд, PC mall
Саммит Компьютер Технологи ХХК, Улаанбаатар-14193, Монгол улс

7011-3535

Visit us:
www.pc-mall.mn

Join us on Facebook
http://www.facebook.com/PCmallOfficial

BOSE®
Better sound through research®

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ТВ ХУВИЛБАР



Манай сэтгүүлийн үнэнч уншигч та бидний уран бүтээлийг мөн телевизээр үзэх боломжтой боллоо.

“Economy” ТВ студи улс оронд тулгарсан бүхий л асуудал, иргэн, бизнесмэнийг эмзэглүүлсэн аливаа сэдвийг цуврал нэвтрүүлэгтээ шууд хөндөн, шууд нэвтрүүлнэ. Тиймээс анхны бүтээл болох “”Зантгар төр” нэвтрүүлэг олны хүртээл болгох гэж байна.

“ЦЭНХЭР СУВДНЫ ҮНЭГҮЙДЭЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Гарах телевиз: NTV

Гарах өдөр: Мягмар гариг, 2014.I.28

Гарах цаг: 21:50

Уншигчдийн маань мэргэн дүгнэлт, үзэгчдийн минь онч үгс бидний бүтээлд том дэм болох билээ.

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:
Б.Цогзаяабаатар /9919-0715/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Э.Зоригт
Х.Хулан
Б.Үүрийнтуяа
Б.Бямбадорж

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь
ВЭБ МАСТЕР: Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Бариажав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:
М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ: Ц.Соёолмаа
ЗУРАГЛААЧ: Ш.Гантуул
КОМПЬЮТЕР ГРАФИКЧ: Т.Баярсайхан

ХАЯГ:
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,
Их сургуулийн гудамж. AB center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

ОНЛАЙН ЗАХИАЛГЫГ

http://mongolianeconomy.imedia.mn/

IKH KHARANGA

Сар шинийн мэнд дэвшүүлье...

Мэдээллийн нэгдсэн сан гэж юу вэ?

* Logo3s.mn
* Reclam6s.mn
* Mobile web
* Application Reclam6s
  /App store, Playstore/
* Реклам мэдээллийн сан
* Media сурталчилгаа





Эрж хайсан зүйлээ

RECLAM6S
application - aac

TOUCHSCREEN TV
Медиа
сурталчилгаа

1.ВИДЕО РЕКЛАМ
2.ФОТО
ТАНИЛЦУУЛГА
3.ТЕХТ ЗАР /УРСДАГ/

LOGO3S.MN



RECLAM6S.MN
MOBILE WEB





Медиа сурталчилгаа



Хуруугаа хүргээд, хүссэн мэдээллээ...

Харилцах утас:
7010-0156, 9111-6586

АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР

The power to do more

БАТАЛГААТ PC SERVICE CENTER 3 ЖИЛ ХУГАЦАА

DELL OPTIPLEX 3010

Business class performance desktops



CPU	RAM	HARD DISK	DVD	
Intel Core i3-3220	4GB DDR3	500GB HDD	DVD/RW	E1914H 18.5”

PC mall®
СҮЛЖЭЭ ИХ ДЭЛГҮҮР

www.pc-mall.mn

7011-3535, 7012-3535

АГУУЛГА

БИЗНЕС

10 Төр өмчөөс татгалзахын шалтгаан

12 Газрын тосны тухай хуулийн өөрчлөлт

13 Тэгш хүртээмж төгс хөгжил

14 “Баянгол”-ын маргааш

ЭДИЙН ЗАСАГ

16 “Төрийн бодлогод байгаа бизнесийн санаархал байдлыг бүр дордуулж байна”

23 Үнийн шуургатай цагаан сар

24 Төрөөс баримтлах эрдэс баялгийн бодлого

25 “Хүрэн” Монгол

26 Шинэ эхлэл

27 Ам.долларын ханга

28 Уналтаас сорилт өөд

31 Эдийн засгийн ухаан юуг судалдаг вэ

32 Хоолонд нуугдах хор

34 Шинэчлэгдэх үү...

35 Төгсгөлгүй өрсөлдөөн

37 Цагийн менежмент

“Монгол Улсын 2013 оны Шилдэг сэтгүүл”





“MONGOLIAN ECONOMY”
СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН
Монголын бизнесийн зөвлөлийн
ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy”
сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД
“Рио Тинто” компанийн Зэсийн
группын Олон улсын үйл ажилллагаа
эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ
ЭЗХЯ-ны Инновац, төр, хувийн
хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН
МІН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ
СЭЗДС-ийн
Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА
“Пийбоди Энержи” компанийн Монгол дахь
хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал
хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС
Эдийн засгийн судалгаа,
эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

МОНГОЛД



Сангийн яамнаас өнгөрсөн оны хамгийн их татвар төлсөн аж ахуйн нэгжийг танилцууллаа. Үүнд “Эрдэнэт” үйлдвэр 362.9 тэрбум төгрөгийг нийлүүлж тэргүүлэв. АПУ хувьцаат компани 153.9 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэн удаалжээ. Дараах байрт “Оюутолгой”, “Монгол Алт” “Тавантолгой”, “Энержи Ресурс” компаниуд багтсан аж. Татвар төлөлтийн хэмжээгээрээ уул уурхайн компаниуд зонхилж байгааг эндээс харж болох юм.

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн дөрвөн чиглэлээр судалгаа хийж байна. Эхнийх нь “Чингис бондын эдийн засагт үзүүлж байгаа нөлөө”. Тус судалгааны дүгнэлт болоод зөвлөмжийг манай сэтгүүл ирэх дугаартаа нийтлэх болно. Мөн төмрийн хүдэр олборлох салбар Монголын эдийн засагт ямар үр ашигтай талаарх удаах судалгааны үр дүнг ч мөн адил уншигч танд ээлж дараатай танилцуулах юм. Үүнээс гадна Тавантолгой төсөл болон Тавдугаар цахилгаан станцын эдийн засагт үзүүлэх нөлөө гэсэн бодлогын судалгаа дээрх судалгааны хүрээлэнд хийгдэж буй.

Өнгөрсөн оны төсвийн орлого 1.5 их наяд төгрөгөөр тасрах эрсдэл байгааг өмнө нь мэдээлж байсан. Тэгвэл оны сүүлч буюу арванхоёрдугаар сарын байдлаар төсвийн орлого 5.8 их наяд төгрөг, зарлага нь 6.2 их наяд төгрөгтэй тэнцжээ. Өөрөөр хэлбэл, 2013 оны төсвийн орлогын 80 хувь нь бүрдсэн. Харин манай улсын гадаад өр 8.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 49.7 хувьтай тэнцэж байгааг Сангийн сайд Ч.Улаан хэллээ. Тус яамны мэдээлж байгаагаар өнгөрсөн онд эдийн засаг 11.5 хувиар өссөн байна. Манай улс “Чингис” бондын зээлийн хүүд жилд дунджаар зээлийн хүүнд 50-60 сая ам.долларыг төлж буй. Энэ хэмжээ ирэх 2015 оноос эхэлж 80 сая ам.доллар болж өсөх юм.



Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр 2015 оноос боловсруулах хүдрийнхээ хэмжээг жилд 35 сая тоннд хүргэхээр болжээ. Үйлдвэрлэлийнхээ хэмжээг ийн нэмэгдүүлэхийн тулд техник технологийн шинэчлэл хийхээр болсон байна. Ингэснээр хүчин чадлаа жилдээ 10 сая тоннд хүргэх юм. Үр дүнд нь баяжмал дахь зэс 118.4 мянган тонноос 135.4 мянган тонн болох аж. Үйлдвэрлэл нэмэгдсэнээр хөрөнгө оруулалт 336 сая ам.долларааас 524 сая ам.доллар болно. Мөн цэвэр ашиг нь хоёр дахин буюу 642 сая ам.долларт хүрэхээр байна. Хүдэр олборлолтыг 2015 оноос 35 сая ам.долларт хүргэснээр 2030 он хүртэл жилд дунджаар 132.4 мянган тонн зэсийн баяжмал буюу дурдсан хугацаанд нийт 2780.3 мянган тонныг үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа аж.


Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 2012 оныхоос 495.7 сая ам.доллар буюу 4.5 хувиар буурчээ. Үүнээс экспорт 112.0 сая ам.доллар буюу 2.6 хувь, импорт 383.7 сая ам.доллар буюу 5.7 хувиар буурсан байна. Экспортын 96.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл, үнэт ба хагас үнэт чулуу, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үслэг эдлэл эзэлж байгаа аж. Мөн Монгол Улс өнгөрсөн онд дэлхийн 135 оронтой худалдаа хийжээ.

Өнгөрсөн жилийн эцсийн байдлаар барилга угсралт, их засварын ажлын үнийн дүн 1452.2 тэрбум төгрөг болсон талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээлжээ. Үүний 91.3 хувь буюу 1326.3 тэрбум төгрөг нь дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажил байгаа аж. Үлдсэн хувийг нь гадаадынхан хийсэн байна. Энэ нь 2012 оныхоос 640.9 тэрбум төгрөг буюу 79 хувиар өссөн дүн бөгөөд үүнд дотоодын компанийн хийсэн барилга угсралт, их засварын ажил 77.3 хувиар өсчээ.

Татварын бус орлого (тэрбум төгрөгөөр)



Татварын орлого



ДЭЛХИЙ ДАХИНД

АНУ-ын Холбооны нөөцийн банкны ерөнхийлөгчөөр 67 настай Жанет Елленийг томилохоор болжээ. Тэрбээр тус банкны дэд ерөнхийлөгчөөр ажилладаг аж. Түүнийг 56 сенатч дэмжиж, 26 нь татгалзжээ. Гэхдээ цаг агаарын таагүй байдлын улмаас олон сенатч уг санал хураалтад оролцож чадаагүй аж. Шинэ Ерөнхийлөгч ирэх сарын 1-нд албан тушаалдаа томилогдохоор болжээ. Холбооны нөөцийн банк зуун жилийн түүхэндээ анх удаа эмэгтэй тэргүүнтэй болж байгаа аж.



БНХАУ-д энэ онд таван хувийн банк шинээр үйл ажиллагаа явуулж эхлэхээр байна. Энэ нь санхүүгийн салбараа хөгжүүлж, өрсөлдөөнийг сайжруулах зорилготой аж. Банкуудыг тус улсын зохицуулалтын хорооны дор эхлээд туршилтын журмаар ажиллуулж үзэх юм байна. Өдгөө банкуудын бүтцийг өөрчлөх, шинээр байгуулахад хувийн санхүүжилтийг нь ашиглахаар төлөвлөж буй. Тус улс хаалттай санхүүгийн салбараа нээлттэй болгох. Эдийн засгийн өсөлтийн шинэ давалгааг бий болгохоор хүчин чармайлт тавьж байгаа аж.



SOCHI 2014

ОХУ-ын Сочигийн өвлийн олимпийн тоглолт эхлэхэд сар хүрэхгүй хугацаа үлдсэн. Аюулгүй байдалтай холбоотойгоор 30 гаруй мянган цагдаа, цэргийг олимпийн хотхонд ажиллуулж байгаа аж. Энэ нь Хойд Кавказын лалын бүлэглэлийн довтолгооноос сэргийлэх зорилготой. Учир нь тус бүлэглэлийн тэргүүн, Чечений босогчдын удирдагч Доку Умаров нь олимпийн тоглолтод саад учруулахаар заналхийлж буйгаа албан ёсоор мэдэгдсэн юм.

Samsung Electronics ухаалаг гар утас, электрон бараа үйлдвэрлэгч дэлхийн хамгийн том компанийн ашиг өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд буурчээ. Үйл ажиллагааны ашгаа 7.8 тэрбум ам.доллар байх болов уу гэсэн хүлээлттэй байв. Гэтэл энэ нь өмнөх улирлаасаа 18 хувиар буурчээ. 2012 оны эцсийн улиралтай харьцуулахад зургаан хувиар буурсан үзүүлэлт аж. Тус компани ашиг буурсан шалтгааныхаа талаар мэдэгдээгүй байна. Гэвч гар утасны борлуулалтын ашиг нь буурсантай холбоотой хэмээн шинжээчид үзэж буй.





Лондон өнгөрсөн онд үл хөдлөх хөрөнгөд хийх гаднын хөрөнгө оруулалтын орчноороо хамгийн шилдэг хотоор шалгарчээ. 2012 онд Нью Йорк хот жагсаалтыг тэргүүлж байсан бол энэ удаад хоёрдугаарт оржээ. АНУ-ын Сан Франциско хот гуравдугаарт, Хьюстон дөрөвдүгээрт, Лос Анжелес тавдугаарт тус тус орсон байна. Харин АНУ нь хөрөнгө оруулалтын хувьд хамгийн тогтвортой, эрсдэл багатай улс гэсэн байр сууриа хадгалж үлджээ. Энэ ангиллаар Герман хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. ■



ОНЦЛОХ СЭДЭВ

ТӨР ӨМЧӨӨС ТАТГАЛЗАХЫН ШАЛТГААН

Б.АЛТАЙ

Монгол Улс том төрөөс ухаалаг төрлүү шилжих гэж оролдож байна. Уг шилжилт нь эдийн засагт шинэ боломж, зах зээлд тэгш өрсөлдөөнийг урин дуудах нь дамжиггүй. Үүнийг бизнес эрхлэгчид мөрөөдөж ирсэн. Өнөөгийн зах зээлийн хэм хэмжээг эвдээд буй төрийн оролцоотой компаниуд оршин тогтнохын тулд өөр хоорондоо нэгдээд эхэлсэн. Тэдний үйл ажиллагааны зардлыг төр дийлэхгүй нь гэдгээ ойлгож, нэгдэж, нийлүүлэх. Зарим нэгийг нь хувьчлах чиглэлд онцгой анхаарах болов.

Ингэснээр төрийн өмчит зарим компани илүү хүчирхэгжиж, томорч байна. Үр дүнд нь төсөвт ирэх ачаалал багасч, урсгал зардал буурах, менежмент сайжрах давуу тал ажиглагдаж байгаа юм. Өмнө нь байсан тархай бутархай төрийн өмчит компаниуд нэг удирдлагын төвтэй болсноор төрд мэдээж ашигтай. Гэхдээ энэ нь зах зээлийг гажуудуулж мэдэх эрсдэл тээж байгаа нь нууц биш ээ. Тухайлбал, уул уурхайн салбарт төрийн нэрээр овоглосон “Эрдэнэс МГЛ” хэмээх “вант улс” бий болж байна. Тэд зах зээлд томоохон тоглогч болохоор атгасан барьцаа лавшруулж эхэлсэн.

Гэхдээ нэг зүйлийг сануулахад төрийн оролцоотой компани, аж ахуйн нэгж бүр ашигтай ажилласан тохиолдол бага. Тэр тусмаа, манай улсад. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн ер нийтдээ өнгөрсөн оны байдлаар 44.2 тэрбум төгрөгт хүрчээ. Үндсэн төлбөр нь 32.5 тэрбум бөгөөд хүүгийн төлбөрт 11.7 тэрбум төгрөг тушаасан байна. Зээлийн хугацаа хэтэрсэн авлагын эргэн төлөлт 7-20 жилийн хэтрэлттэй байгааг Үндэсний аудитын газраас мэдээллээ. Дээрх тоон үзүүлэлт төр бизнесийн салбарт хэт шургаж болохгүйг сануулсаар.

Төрийн оролцоо хэтийдсэн одоогийн тогтолцооноос нийтээр “урваж”, бизнесийн салбар дахь төрөөр овоглосон компанийн тоог эрс цөөлөх бодлого хэрэгжээд эхэлсэн гэж ойлгож болохоор. Өөрөөр хэлбэл, төр аль болох бизнесийн салбараас зайлсхийх. Өөрийн оролцоог багасгах гэж тодорхой ажлууд хийж байгааг энд тэмдэглэе. Үүний хүрээнд “Эрдэнэт” үйлдвэрийн Монголын эзэмшлийн 51 хувийг Засгийн газрын тогтоолоор “Эрдэнэс МГЛ” компанид шилжүүлсэн. Мөн “Оюутолгой” компанийн Монголын талын 34 хувийг шилжүүлэх талаар яриа хэлцэл өрнөж байгаа аж.

Тэгвэл “Эрдэнэс МГЛ” гэж хэн бэ. Тус компани нь Засгийн газрын тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг түшиглэн байгуулагдсан. Ашигт малтмалын салбар дахь төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн мэдлийн хувьцааг борлуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй. Төрийн өмчит компаниудыг өөртөө элсүүлээд буй “Эрдэнэс МГЛ” ХХК нь дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үндэсний корпораци болохоор зорьж буй. Тус компанийн мэдэлд “Багануур”, “Шивээ-Овоо” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өнгөрсөн онд шилжүүлсэн. Мөн “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Оюутолгой” хэдийнэ багтсан. “Эрдэнэс Тавантолгой” нь “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн охин компани. Үүгээрээ “Эрдэнэс МГЛ” Монголын хамгийн том төрийн өмчит аж ахуйн нэгж болж байгаа юм. Үүнээс гадна Асгатын мөнгөний орд, Цагаан суваргын зэс, молибден, Нарийн сухайтын нүүрсний орд,



Баргилт, Төмөртэй, Төмөртолгойн төмрийн хүдрийн ордыг “Эрдэнэс МГЛ” компанид тус тус шилжүүлэх аж.

Манай улсын хувьд төрийн өмчит компани, аж ахуйн нэгж байгуулах “моод” нэг үе дэлгэрсэн. Ингэснээр бизнесийн салбарт хутгалдах төрийн оролцоо түгээмэл үзэгдэл болсныг тус салбарт ажиллаж буй хэн бүхэн хэлдэг. Бизнест нь оролцдоггүй, өрсөлддөггүй, саад болдоггүй төртэй байхыг ажил хэрэгч хүмүүс хүсдэг болохыг МҮХАҮТ-ын бизнесийн орчны судалгаанаас харж болно. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж төр аж ахуйн нэгж байгуулаад, бизнес эрхлэгчидтэйгээ өрсөлдөөд байх ёсгүйг ч сануулсан. Тиймээс Ерөнхийлөгч “Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хуулиар хязгаарлая” хэмээн энэ чиглэлийн хуулийн төсөл боловсруулах шаардлага байгааг онцолсон нь бий.

Тус хуулийн төслийн үндсэн агуулга нь шинээр төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн нэгж байгуулахыг хориглох. Зөвхөн УИХ-аас хуулиар байгуулахын зэрэгцээ тухайн ТУЗ-ийг төрийн албанаас тусгаарлаж, компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх нь оновчтойг тэмдэглэсэн. Тухайлбал, төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” өөрсдөө нүүрсээ худалдах бус зөвхөн бодлого, хяналтаа тавиад явах боломжтойг Ерөнхийлөгч өгүүлсэн. Мөн гэрээний хэрэгжилтэд анхаарал хандуулж, хариуцлага тооцоод явах нь оновчтойг зөвлөв. Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төсөл биелэлээ олсон тохиолдолд “Эрдэнэс МГЛ” компанийн ТУЗ-д бүтцийн өөрчлөлт гарна гэсэн үг.

Тэгвэл манай урд хөрш мөн адил бизнесийн салбар дахь төрийн хэт оролцоог халахаар шийджээ. БНХАУ-ын талаар хийсэн СЭЗДС-ийн эдийн засгийн судалгаагаар Хятадын 500 үйлдвэрийн компанийн 50 хувь, мөн дээрх тооны үйлчилгээний салбарын 61 хувийг тус тус төрийн өмчит компани эзэлж байна гэсэн өндөр тоо гарсан. Эл байдлыг засах үүднээс БНХАУ-ын шинэ удирдагч “Хятад мөрөөдөл” бодлогынхоо хүрээнд бизнесийн салбар дахь төрийн оролцоонд босго тавиад эхэлжээ. Үүний хүрээнд өмчийн олон хэлбэрийг дэмжиж холимог өмчийн тогтолцоот эдийн засгийг идэвхтэй хөгжүүлэхээр зэхсэн байна. Хөрш зэргэлдээ орны бодлогын шинэчлэлийг энд зориуд дурдсан юм.

“Төр хамгийн муу менежер” гэх. Үүний нотлох баримт хөвөрсөөр. Улсын хэмжээнд буй 94 төрийн өмчит компани байгаагаас 34 нь алдагдалтай ажилладаг болохыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Цогтбаатар хэллээ. Төрийн өмчийн хорооны хийсэн судалгаагаар 34 компанийн 13 нь тэрбум төгрөгөөс дээш алдагдалтай ажиллаж байгаа. Түүнчлэн 100 саяас нэг тэрбум төгрөгийн алдагдалтай 10 гаруй компани байгаа аж. 5-100 сая төгрөгийн алдагдалтай мөн тооны компани төсвийн татаасаар амьдарч байна. Тэдний алдагдалтай ажиллаад байгаа гол шалтгаан нь төрийн өмчийн удирдлага, менежменттэй холбоотой болохыг Д.Цогтбаатар өгүүллээ. Нөгөөтэйгүүр төрийн өмчид хандах хүмүүсийн хандлага өөрчлөгдөхгүй байгаа нь алдагдалтай ажиллахад хүргэдэг байна. Тиймээс төр бизнесийн орчинд тоглогч байхаас татгалзаж, үндсэн ажлаа хийхээр болсныг эл өөрчлөлт гэрчилнэ. ■



Фотог Б.Бямба-Очир

ШИГТГЭЭ

“Эрдэнэс МГЛ” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/

ТУЗ-ын дарга: Ч.Сайнбилэг */Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга/*

Гишүүд: Б.Батзаяа */Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга/*
Р.Жигжид */Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга/*
Б.Шинэбаатар */Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга/*
П.Гантулга */Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга/*
Н.Энхтуяа */Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/*
Э.Батбаяр */Сангийн яамны Төсвийн бодлогын газрын Орлогын хэлтсийн дарга/*
Д.Баярсайхан */Санхүүгийн зохицуулах хорооны дарга/*
Б.Жавхлан */Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч/*

“Эрдэнэс МГЛ” компанийн удирдлагын баг

Гүйцэтгэх удирдлага:
О.Сайнбуян */Гүйцэтгэх захирал/*
Г.Тэмүүлэн */Дэд захирал/*
Б.Ариунболд */Дэд захирал/*

БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙ

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

С.АЗ

Манай улс 1991 оноос хойш Газрын тосны тухай хуульдаа гар хүрээгүй. Нийгэм хөгжихийн хэрээр улс орны эдийн засгийн чадавх сайжирч, бид уул уурхайн баялгаа экспортолж, гадаад орнуудтай хамтын ажиллагаагаа өрнүүлж буй. Энэ хүрээнд манайхан хар алт гэгддэг нүүрсээ шингэрүүлж, нефть гаргаж авахаар судалгаа шинжилгээ хийж эхэлсэн. Тэр утгаараа Монголд өрнөсөн ардчилалтай нас чацуу гэж хэлж болох уг салбарын хуульд зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болжээ. Тиймээс Засгийн газрын 2008 оны Арванхоёрдугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 80 дугаар тэмдэглэлд “Газрын тосны тухай хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах. Төрийн байгууллагын эрх хэмжээг тодорхой болгон, төлбөр (роялти)-ийн хувь хэмжээ, түүнийг ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх. Түүнчлэн тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох. Газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгон хуульчлах шаардлагатай” гэж тэмдэглэсэн байна. Харин өнгөрсөн хаврын чуулганы төгсгөлд Уул уурхайн сайд Д.Ганхуяг Газрын тосны тухай хуулийг шинэчлэн найруулснаа УИХ-ын даргад өргөн барьсан. Төсөлд 2008 оны Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан хүчин зүйлийг тодорхой болгохоор тусгажээ.

Энэ хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар олон эерэг өөрчлөлт орох тухай албаныхан мэдээллээ. Чухам ямар гол гол өөрчлөлт орохыг дор сийрүүлэв.

-Газрын тосны ордын ашиглалт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн харилцааг нарийн тусгаагүй, ойлгомжгүй, бусад хуультай зөрчилдсөн заалтуудгүй болох

-Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан татварын нөхцөлийг хадгална. Түүнчлэн хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчин бүрдэх

-Газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн ялгаа тодорхой болно. Мөн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тогтолцоо иж бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх

-Цөмийн энерги, ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай давхцах асуудал гарахгүй байх эрх зүйн орчин бүрдэх

-Монгол Улсад баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг дотоодоос хангах. Улмаар газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарлаас гарах, экспорт нэмэгдэх, гадаад валютын нөөц өсөх, ажлын байр нэмэгдэх

-Уламжлалт бус газрын тосны эрх зүйн орчин тодорхой болох

-Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хөрөнгө оруулалт, бизнесийн орчны өрсөлдөх чадвар нь олон улсын дундаж түвшнээс дээгүүр хэвээр хадгалагдах

-Нөөц ашигласны төлбөрийн хувь нь газрын тосонд 5-15, уламжлалт бус газрын тосонд 5-10 болсон байна. Тусгай зөвшөөрлийн болон нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай хамаарах сум, дүүргийн, 20 хувийг аймаг, нийслэлийн, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлэх

-Ашигт газрын тосны Засгийн газарт оногдох хувь хайгуулын болон бүтээн байгуулалтын зардлыг нөхөхөөс өмнө 50–иас доошгүй, нөхсөний дараа 60 болох

-Гэрээлэгч ашиглалтын үед орон нутагтай байгуулах хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу өөрт ногдох газрын тос, уламжлалт бус газрын тосны орлогоос орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлж болох ажээ.

Хууль хэлэлцэн батлагдан үед дээрх онцолсон өөрчлөлтүүд дүрээ хувирган гарч ирэх талтай тул баттай зүйл биш гэдгийг тэмдэглэе.



Хуулийн төслийг УИХ-ын намрын эээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөөд буй. Намрын чуулган сар хүрэхгүйн дараа завсарлахаар байгаа ч уг хуулийн төслийг УИХ-ын Байнгын хороод, чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөг хүртэл хэлэлцээгүй байна. ■

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

ТЭГШ ХҮРТЭЭМЖ ТӨГС ХӨГЖИЛ

Ч.ЛУТАА

Залуухан Монголын Зээлийн батлан даалтын санд шийдвэрлэх асуудал олон. Түүний нэг нь хүртээмж. Жижиг дунд үйлдвэрлэл /ЖДҮ/ эрхлэгч, арилжааны банкны зээл ганзага нийлүүлж чадалгүй өдий хүрсэн. Хэдийгээр уулзаж өгдөггүй хоёр талын ашиг сонирхлыг нийлүүлэхээр “Зээлийн батлан даалтын сан”-г байгуулсан ч суусан газраасаа шороо атгачихмаар ЖДҮ эрхлэгч бүхэнд батлан даалтын сан хүрч үйлчилж чадаж байна уу гэдэг эргэлзээтэй. Тэр дундаа хөдөө, орон нутгийнханд батлан даалтын сан хол хөндий. Тоо баримтаас харахад тус сан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 15 тэрбум төгрөгийн зээлэнд 4.1 тэрбум төгрөгийн батлан даалтыг 61 ЖДҮ эрхлэгчдэд гаргажээ. Үүнээс Нийслэлийн ЖДҮ, жижиг бизнес эрхэлдэг 45 аж ахуй нэгжид батлан даалт гаргасан байна. Гэтэл орон нутгаас батлан даалтад 16 л хамрагдсан байх жишээтэй. Уг нь ЖДҮ хөгжихийн хэрээр хувийн өмчийн шинэ салбар бий болох үндсэн суурь, нөхцөлийг бүрдүүлдэг. /Энэ талаар өмнөх дугаарын нийтлэлдээ дэлгэрэнгүй дурдсан/ Тэр дундаа орон нутагт бий болж байгаа ЖДҮ-үүд нь өөр хоорондоо болон том үйлдвэрүүдтэй түүхий эд, техник технологийн холбоог бий болгодог. Тэд үндэсний үйлдвэрлэлийг сэргээхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Энэ хэмжээгээр хүн амын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, ажлын байр шинээр бий болгоно гэсэн үг. Тиймээс хөдөө орон нутагт зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээг хүргэх шаардлага





Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

бий аж. Тус сангийн мэргэжилтэн Б.Эрдэнэсувд “Одоогоор батлан даалтын сан нь орон нутагт салбар нэгжгүй. Мөн орон нутгаас батлан даалтын хүсэлтийг хамтран ажилладаг банк, санхүүгийн байгууллагын салбар нэгжээр дамжуулан хүлээн авдаг. Одоогийн байдлаар батлан даалтын хүсэлтийг “Төрийн банк”, “Голомт”, “Капитал”, “Хаан”, “Хас”, “Чингис хаан”, “Худалдаа хөгжил”, Капитрон”, “Улаанбаатар хотын банк”, бүх ББСБ-ын салбар нэгжээр дамжуулан авч байгаа” гэв.

Туршлага

Ер нь олон улсын тэр дундаа Солонгос, Тайвань, Япон, Малайз зэрэг улсын Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны туршлагаас харахад эхлээд нийслэлдээ зээлийн батлан даалтын санг байгуулсан байдаг. Үүнийхээ дараа үйл ажиллагаа нь тогтворжоод ирэхээр орон нутагт салбар нэгжээ байгуулдаг юм билээ. Гэхдээ уг сан хэзээ хаана байгуулагдсан гэхээсээ яагаад бий болсон бэ гэдэг нь сонин. Олон улсад Зээлийн батлан даалтын сан бол бүс нутгийн хөгжил, хүн амын амжиргааг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шууд ба шууд бусаар нөлөөлдөг гэж үздэг. Тиймээс тухайн улсын хаана ажилгүйдэл, ядуурал их байна тэнд батлан даалтын санг түрүүлж бий болгодог. Үүний жишээ нь Хятад улс. Тус улс алслагдсан нутгийн хөгжлийг дэмжих, хүн амынхаа амжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахын тулд эхлээд орон нутагт зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулжээ. Үүнийхээ дараа нэгдсэн холбоотой болсон түүхтэй. Энэ бодлогынхоо ач тусыг урд хөрш өдгөө үзэж чинээлэг дундаж давхаргынхаа тоогоор дэлхийд толгой цохиж байна. Өдгөө Хятад улсын дундаж давхаргын иргэдийн тоо Англи улсын нийт хүн амаас дөрөв дахин их болжээ. Эндээс Зээлийн батлан даалтын сан нь тэгш хүртээмжийг бий болгосноор эдийн засгийн өсөлтийг хөгжил болгох нэг хөшүүрэг гэдэг нь харагдана.


Манай зээлийн батлан даалтын сангийнхан зүгээр суугаагүй аж. »

Энэ онд орон нутагт салбар нэгжээ байгуулахаар төлөвлөсөн байна. Төв орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүдийг төлөөлөгчөөр ажиллуулах замаар сангийн тухай мэдээллийг орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчид өгүүлэхээр төлөвлөж байгаа аж. Мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг батлан даалтад өргөнөөр хамруулах үүднээс "Зээлийн батлан даалтаар Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих Загвар хөтөлбөр"-ийг боловсруулжээ.

Хөтөлбөрийн зорилго

- Тухайн дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх

Хөтөлбөрийн хүрээнд нэн түрүүнд ЖДҮ эрхлэгчдийг зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдах бололцоог нэмэгдүүлнэ. Ингэж чадвал ЖДҮ-ийг дэмжин ажлын байрыг шинээр бий болгож, нийслэл, дүүргийн эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах талаар Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанхуяг хэлсэн. Мөн орон нутагт уг сангийн үйл ажиллагааг хүргэхийн тулд загвар хөтөлбөрийг хоёр аймаг, нэг дүүргэт хэрэгжүүлэхээр болжээ. Үүнд Улаанбаатар хотын алслагдсан дүүргэ болох Багануур багтсан аж. Одоогоор Багануур дүүргийн ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, хөтөлбөрийг баталгаажуулжээ.



Энэ нь хэрэгжсэнээр Багануур дүүргэт тэргүүн ээлжинд хөгжүүлэх салбарыг тодорхойлох. Орон нутгийн онцлогт тохирсон ЖДҮ-г дэмжих бодлого явуулах аж. Товчхондоо хүртээмжийг сайжруулах ажил нь энэ оноос эхэлж байна.

Шинэхэн бөгөөд туршлагагүй Зээлийн батлан даалтын сан эдийн засгийн өсөлтийн энэ үед хөгжлийн гадна үлдээд байдаг хөдөө, орон нутагт нарны эртэд хүрч чадвал монголчууд нийтээрээ өөдлөх боломж бүрдэх юм.

ТОП 20

"БАЯНГОЛ"-ЫН МАРГААШ

Б.ЭРДЭНЭ

Улаанбаатарт буй дөрвөн одтой зочид буудлын нэг нь Баянгол. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй тус хувьцаат компани үйл ажиллагаа явуулаад хагас зууныг үдэж буй. "Баянгол зочид буудал" нь 1991 онд хувьцаат компани болсон. Өдгөө хөрөнгийн биржийн "ТОП-20" индекст багтдаг томоохон хувьцаат компаниудын нэг гэж хэлж болно. Хувьцааны багц нь цөөхөн хүнд төвлөрсөн байдаг. Тиймээс цаашид нэмэлт хувьцаа шинээр гаргах замаар хувьцааны төвлөрлийг сааруулах боломжтой.

Компанийн зүгээс шинээр хувьцаа нэмж гаргах асуудал судалгааны шатанд яваа аж. Гэхдээ хуулийн таатай нөхцөл болон судалгааны ажлыг үндэслэн компанийн ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх юм байна. Үүнээс гадна зочид буудлын шинэ өргөтгөл барихаар зураг төслийг боловсруулж байгаа аж.

Шинээр барих зочид буудалд шаардлагатай хөрөнгийг босгоход хоёр сонголт бий гэнэ. Эхнийх нь нэмэлт хувьцаа гаргах. Хоёр дахь нь гаднаас хямд эх үүсвэр бүхий урт хугацаатай хөрөнгө оруулалт буюу зээл авах. Үүнээс хамгийн эрсдэл багатай нь нэмэлт хувьцаа гаргаж төслөө мөнгөжүүлэх гэж Монголын арилжаа эрхлэгчдийн холбооноос зөвлөсөн байна. Гэхдээ дээрх өргөтгөлд шаардлагатай хөрөнгө оруулалт одоогоор тодорхой болоогүй байна.

"Баянгол зочид буудал" "Женко" группын охин компаниудын нэг.

Өөрийн хөрөнгө:
28.6 тэрбум
Хувьцаат капитал 2.1 тэрбум
Хуримтлагдсан ашиг 26.4 тэрбум

Үйл ажиллагааны зардал:
3.822.541 мян.төг

Цэвэр ашиг:
3.289.645 мян.төг

Ногдол ашиг тараасан эсэх:
Нэгж хувьцаанд 350 төгрөгийн ногдол ашиг тараасан

Өр зээл:
5.5 тэрбум төгрөг

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо:
1155

ТУЗ-ийн гишүүний тоо:
9

ТУЗ-ийн хараат бус гишүүний тоо:
3

Компанийн нийт ажилтны тоо:
179 /орон тооны/

Үйл ажиллагааны төрөл:
Зочид буудал, зоогийн газар

Хувьцаат компанийн хувьд жил бүр тогтмол ногдол ашиг хуваарилдаг. 2013 оны үйл ажиллагаагаа дүгнэсэн ТУЗ-ийн хурал нь ирэх дөрөвдүгээр сарын дундуур болох юм.

Компанийн эрхэм зорилго: Зочдоо дээдэлсэн, зочин бүртээ чин сэтгэлээсээ үйлчлэх.

Өнгөрсөн онд тус компани хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийг хийж, тохиолог аюулгүй орчинг бүрдүүлэх. Мөн мэргэшсэн, ур чадвартай ажиллагсад нь инээмсэглэн үйлчилгээг зочин бүрт хүргэх зорилт тавин ажиллажээ. Ингэснээр буудлын орашиглалт болон хоол үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, компанийн орлогыг 2012 оны гүйцэтгэлээс 6.5 хувиар нэмэгдүүлэхээр зорьжээ.

Үүнээс гадна компанийн татварын дараах цэвэр ашгийг өмнөх оныхоос 0.9 хувиар өсгөх зорилт дэвшүүлсэн байна. Дээрх зорилго, зорилтын хүрээнд 1.047 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, гадна дотно засвар тохижилтын ажлыг хийж, зорилт төлөвлөгөөгөө 96 хувьтай биелүүлжээ. Энэ онд “Баянгол”-ын 50 жилийн ой тохионо.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд “Баянгол” “Женко-34- жүдо бөхийн клубын тамирчдыг өөрийн үндсэн ажилтнаар цалинжуулж, дэмжин ажилладаг байна. Мөн Япон улсаас Монголын зүрхний өвчтэй хүүхдүүдэд үзлэг хагалгаа хийхээр ирсэн зүрхний эмч нарыг жил бүр өөрийн зочид буудалдаа үнэ төлбөргүй байрлуулж, бусад хандив тусламж үзүүлсэн аж. Энэ нь мөнгөн дүнгээр илэрхийлэхэд зөвхөн өнгөрсөн онд гэхэд 50 гаруй сая төгрөгийг зориулжээ.

“Баянгол” мөн жил бүр тасралтгүй ногдол ашиг тарааж иржээ. Ногдол ашгийн хэмжээ нь нэмэгдсээр байгааг дараах тооноос харж болох юм.

	/сая төгрөгөөр/
20098 2010 онд	107.562.000
2011 онд	130.728.629
2012 онд	133.396.000

Компанийн хувьд үйл ажиллагааны зардлаа бууруулах замаар хэмнэлт хийх боломжийг эрэлхийлэх болсон байна. Өнгөрсөн оны хувьд “Баянгол”-д саатах гийчдийн эрс багассан аж. Энэ нь гаднын хөрөнгө оруулалт буурсан. Уул уурхайн салбар уналтад орсонтой холбоотойг тус компанийнхан тайлбарлаж байна. Мөн сүүлийн жилүүдэд нийслэлийн хэмжээнд зочид буудал олноор нээгдэх болсон нь томоохон зочид буудлын зах зээлд нөлөө үзүүлээд эхэлжээ. Нөгөөтэйгүүр жуулчдын тоо дорвитой нэмэгдэхгүй байгаа нь зочид буудлын ашиг, орлогод нөлөөлж байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. ■



Фотог Б.:Эрдэнэ

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

“ТӨРИЙН БОДЛОГО ДАХЬ БИЗНЕСИЙН САНААРХАЛ БАЙДЛЫГ БҮР ДОРДУУЛЖ БАЙНА”



Фотог Э.Зоригт

“Mongolain Economy” сэтгүүлийн дэргэдэх “Economy” ТВ студи. 2014.1.09

Тэмдэглэсэн И.ОТГОНЖАРГАЛ, Э.ЗОРИГТ, С.БАТЗАЯА

“Mongolian Economy” сэтгүүл Монголын эдийн засгийн хөгжлийн түүхийг хэвлэлийн хуудаснаа буулгаж яваа мэргэжлийн сэтгүүлийн хувьд Монгол Улсын нэгэн үеийн хөгжлийг жолоодоход өөрсдийн хөдөлмөр, тэмцлээ зориулсан Ерөнхий сайд асан эрхэм гурван хүнийг редакцидаа урьж, уулзалт зохион байгууллаа. Тэд бол Думаагийн Содном/1984.12.12-1990.3.21/, Шаравын Гунгаадорж /1990.3.21-1990.9.11/, Дашийн Бямбасүрэн /1990.9.11-1992.7.21/ нар.

Тэднийг шинэ оны эхэнд, Цагаан сарын өмнө “Mongolian Economy” сэтгүүлийн редакцийн уулзалт хийгээд тус сэтгүүлийн дэргэдэх “Economy” ТВ студийн анхны хүндэт зочноор урьж оролцуулсандаа бид ч баяртай байна. Ерөнхий сайдын өндөр албан тушаалыг нэгнээсээ эзэлжлэн хүлээн авч байсан түүхтэй энэ эрхмүүд өнөө болтол нэг дор гурвуулаа зэрэгцэж суугаад ярилцлага өгч байсан түүхгүй билээ. Тиймээс манай сэтгүүл эдийн засгийн өнөөгийн байдал, улсын хөгжлийн талаарх тэдний санаа бодлыг нэгэн зэрэг сонсож дуулгах, мөн сэтгүүл болон студидээ он цагийн уртад улам бүр үнэ цэнэтэй болдог баримт, үйл явдлыг үлдээх зорилгоор ийнхүү редакцийн уулзалт хийлээ.

Д.Содном: Монголын хөгжил цаашид дараах дөрвөн замаар явж таарна



-Манай сэтгүүлийн уламжлалт асуулт байдаг. Тэр нь амьдрал ямар байна вэ гэж. Тиймээс энэ асуултаар редакцийн уулзалтаа эхлүүлье?

Д.Содном: Эдийн засаг өсч байна. Тухайлбал, ДНБ-ий өсөлт 2012 онд өндөр гарсан. Энэ эрч өнгөрсөн онд ялимгүй саарсан ч гэсэн бас л хоёр оронтой тооноос буугаагүй. Гэхдээ амьдрал ямар байна вэ гээд харахаар янз бүр л байна. Авхаалжтай, ашигтай бизнес хийж байгаа хүмүүс, малаа сайхан хариулж яваа малчид, сурлага сайтай оюутан, чадварлаг тамирчид өнөөдөр сайхан амьдарч байна. Хөдөлмөрлөх чадвар багатай эсвэл залхуу хэсгийн амьдрал тааруухан л байна.

Ш.Гунгаадорж: Амьдрал алаг тарлан байна. Содном даргын хэлсэнчлэн хувь хүнээс хамаарах асуудал олон бий. Гэхдээ төр, засгийн оновчгүй бодлогоос шалтгаалах зүйл ч байна. Үүнтэй холбоотой ажилгүйдэл, ядуурал гүнзгийрч, баян, хоосны ялгаа улам гаарсаар. Алтан нарыг алгаар хааж болдоггүйн адил энэ асуудал олон түмний нүдэнд ил харагдаж байна шүү дээ. Нэг хэсэг нь өөрсдийн залхуугаас болоод ядруухан амьдарч байгаа. Гэхдээ бүх асуудлыг иргэдийнхээ нуруунд үүрүүлж болохгүй. Ер нь өнөөгийн ядуурал үе үеийн төр,засгийн ухаалаг бодлого дутагдсантай холбоотой.

Д.Бямбасүрэн: Улс орны хөгжил, эдийн засгийг томоор нь харвал монголчууд алдаагүй юм байна. Олон улс дахь Монгол Улсын нэр хүнд, байр суурийг харсан ч тэр. Гэхдээ тус бүрд нь задлаад харвал асуудал бий. Тухайлбал, өнгөрсөн онд Монгол Улс эдийн засгийн томоохон хүндрэл, сорилтыг давлаа. Түүхэнд байгаагүй их өртэй, түүхэнд байгаагүй төсвийн алдагдалтай. Мөн түүхэнд байгаагүй төгрөгийн ханшийн уналттай жилийг үдлээ. Гэхдээ монголчууд тэсэх хаттай юм болохоор хатуу жилийг давж чадсан. Амьдрал ямар байна вэ гэвэл янз бүр л байгаа. Зарим хүний хэлдгээр “Амьдрал сайхан байна. Арвайн гурилаа идэцгээе” гэсэн маягийн яриа байж л байдаг. Чухам бодитоор харвал өнөөгийн нийгэмд ялгарал их байна. Сүүлийн 10 гаруй жилд баялгийн тэгш бус хуваарилалт явсаны улмаас нэлээд асуудал хуримтлагдсаар ирлээ. Гэхдээ эдгээр асуудлыг цаашдаа бага багаар шийдэх байх. Өнөөгийн нийгэм, эдийн засгийн чадавхыг 1990 онтой харьцуулахад миний тооцоолсноор 10 дахин өссөн. Гэхдээ нийт хүмүүсийн амьдрал ингэж өсч чадаагүй. Хэдийгээр ардчилсан нийгэмд хувь хүний амьдрах чадвараас ямар явах нь хамаарах ч төрийн бодлого хаашаа чиглэж байгаагаас хамаарах зүйл олон.

-Өнгөрсөн оны гол тоон үзүүлэлт дээр үндэслэн Д.Жаргалсайхан нийтлэлч “Нинжа эдийн засаг” гэж тодорхойлсон байна. Ингэж тодорхойлох болсон шалтгаан нь монголчууд уул уурхайгаа ухдаг, архи, тамхины үйлдвэрлэлээс татварын ихэнх хэсгийг бүрдүүлдэгтэй холбон тайлбарласан байсан. Энэ байдлыг өөрчлөхийн тулд юу хийх ёстой вэ?

Д.Содном: Монголчуудын хувьд анхаарал хандуулахаас аргагүй эдийн засгийн чухал салбар бол уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал юм. Мөн технологийн салбарыг орхигдуулж болохгүй. Цаашдаа энэ дөрвөн замаар л явж таарна. Тиймээс уул уурхайгаа яаж зөв хөгжүүлэх вэ, хөрөнгө оруулагчидтай хэрхэн харьцах вэ, тэднийг аль талаар нь дэмжих вэ, аль зүйл дээр нь хяналт тавих вэ гэдэгт төрийн зөв бодлого чухал. Үүнтэй холбоотой Ерөнхийлөгчийн санаачилсан “Ухаалаг төр” гэх санаачилгыг улам сайжруулж, авч явах учиртай. Ингэж чадвал манай эдийн засаг зөв хөгжнө.

Ш.Гунгаадорж: Уул уурхай, эрчим хүчгүйгээр улс орныхоо хөгжлийг бий болгоход хэцүү. Тийм ч учраас сүүлийн 10 гаруй жил энэ талаар ярьсан. Уул уурхай тэргүүлэх салбар мөн боловч угсруулаад дагалдах бусад бие даасан томоохон салбарын хөгжлийг дэмжих хэрэгтэй. Тэр дундаа хөдөө аж ахуйг дэмжих цаг болсон. Ер нь хөдөөгийн хөгжилгүйгээр Монгол Улсыг төсөөлөхөд бэрх шүү дээ. Хэрвээ хөдөө, орон нутаг хөгжөөгүй бол манай улс хөгжиж байна гэж хэлэх үндэслэл муутай. Энэ утгаар нь харвал манай төр засаг, хөдөө орон нутгийн хөгжилд тун муу анхаарсан. Манайх хот улс болчих гээд байна. Монгол Улсыг өмнө нь ч одоо ч малгүйгээр, хөдөөгүйгээр төсөөлж байгаагүй. Энэ нь ч учиртай. Тиймээс өнөөгийн төр, засаг уул уурхайгаас гадна хөдөөгийн хөгжлийн талаар ярих, хийх цаг нь болсон. Мал, газар хоёр бол монголчуудын ширгэшгүй баялаг юм. Уул уурхайн шавхагдах баялгаас олсон орлогыг юунд зарцуулах тал дээр ухаан жаахан дутаад байна уу даа.

Д.Бямбасүрэн: Монголын эдийн засгийг маш хүнд өвчтэй бараг хэвтрийн эдийн засаг гэж хэлж болно. Нэг хэсэг Голландд өвчин гэж ярьдаг байсан. Гэтэл ярьсаар байгаад л түүн рүү яваад орчихлоо. Тэжээлгэн тэтгүүлэх, бэлэнчлэх сэтгэхүй Монголд давамгайлж байна. Уг нь хөгжинө гэдгийг өөрсдөө баялаг бүтээх гэж ойлгож болно. Гэтэл сүүлийн үед байгаа баялгаа ухаж аваад, үрэн таран хийчихээд сайхан амьдарч байна гэх хандлага их боллоо. Уул уурхайн баялаг бол бидний бүтээсэн бус өвөг дээдсээс уламжилж ирсэн. Түүнийг нь бид зохистой түвшинд ашиглаж байгаад ирээдүй хойчдоо үлдээх учиртай. Гэтэл өнөөдөр баруун солгойгүй цацаад л байна. Энэ талаас нь харвал манай эдийн засаг хүнд өвчтэй байгаа.

-Та монгол төрийн бодлогод томоохон хэлбийлт гарлаа гэсэн байсан. Түүнийгээ жаахан тодруулахгүй юу?

-Гурван зүйлийг дурдахгүй бол болохгүй нь. Нэгдүгээрт, монголчуудын дунд өр зээлээр баяжина гэдэг ойлголт газар авч байна. Энэ бол ирээдүйнхээ амьдралыг өнөөдөр барьцаанд тавьчихаад сайн сайхан амьдарна гэдэг итгэмээргүй төрийн бодлого. Хоёрдугаарт, хямралыг далимдуулж Хөрөнгө оруулалтын тухай хууль гэж шинээр гаргалаа. Ерөнхийд нь бодоход хөрөнгө оруулагчдыг татахад болохгүй зүйлгүй. Гэтэл энэ нь өөрөө гурван том сөрөг үр дагаварыг дагуулж байна. Эхнийх нь манай эдийн засгийн орон зай задарчихлаа. Хуулиар хамгаалагдсан тогтвортой нөхцөлийн чинээлэг хэсэг. Хажууд нь

“ХҮНСЭЭ БЭЛДЭЖ ЧАДАХГҮЙ БАЙЖ БИД

чадан ядан явж байгаа аж ахуйн нэгж гээд дотор нь хуваачихлаа. Мөн тус хуулийн 12.1.1-д зааснаар... “Гадаадын хөрөнгө оруулагчдад Монголын газрыг 60 жилээр эзэмшүүлнэ. 40 жилээр сунгана” гээд заачихсан. Энэ чинь манай улс газар нутгаа худалдаж амьдрах зам руу орлоо гэсэн үг. Энэ бол сэтгэл хиртхийлгэм мэдээ юм. Түүнчлэн Оюутолгой гэж нэг том асуудал байна. Оюутолгойн гэрээнд зааснаар ашгаа гадагш нь зөөж байгаа гадаадын хөрөнгө оруулагчид өмнөх хуулиар 20 хувийн шимтгэл төлөхөөр байсан. Гэтэл саяын шинэ хуулиар гадаадын хөрөнгө оруулагч ашгаа гадагш нь зөөх нь чөлөөтэй гээд заачихлаа. Ингээд манай эдийн засгийн эрх зүйн асуудал орвонгоороо эргэж жолоодоход тун бэрхтэй боллоо.

Гурав дахь асуудал нь намрын чуулганаар алтны татварыг бууруулах тухай асуудал яригдаж байна. Богд хаант улсын Засгийн газрын үеэс л эрдэс баялгийн татвартай байсан. Алтнаас 16 хувийн татвар авдаг байлаа. Гэтэл манайхан 2.5 болгоно гээд байгаа. Товчхондоо хэн дуртай нь ирээд Монголын баялгийг ухаад аваад яв л гээд байх шиг байна. Ийм өр зээл тавьж, эдийн засгаа жолоодох чадваргүй болж, өөрийн өв баялгийг үнэгүйдүүлэх нь сүүлийн 20 гаруй жилд Монголд орж ирсэн эдийн засгийн алуурчдын номлол юм. Үүнийг нь харвал өнөөгийн Монголын эдийн засгийг “Hitman”-ий эдийн засаг гэж хэлж болно. Ийм л гажуудал руу бид явж байна. Үүнийгээ засах ухаан, тэнхээ байгаа үгүйг мэдэхгүй. Уул уурхай бол анхны хуримтлал үүсгэх салбар учраас бид түших ёстой. Гэхдээ хүнсээ бэлдэж чадахгүй байж бид хөгжиж байна гэж яриад яах вэ дээ.

-Монгол Улс Чингис бондоо зарцуулж байгаа. Самурай бонд гаргалаа. Тиймээс энэ тал дээр та бүхэн ямар бодолтой байна вэ?

Д.Содном: Гол учир нь тэр мөнгийг хэрхэн ашиглах вэ гэдэгт л байгаа юм. Түүнээс биш, бонд гаргах нь буруу биш. Харин тэр бондын мөнгийг буруу ашиглавал ирээдүй хойчдоо гай болно.Тиймээс энэ мөнгийг хариуцаж байгаа Засгийн газар, УИХ-ын гишүүн, яам тамгын газрын ажилчид хоноцын маягийн сэтгэлгээтэй байж таарахгүй. Өөрийнхөө мөнгө шиг сэтгэлээр төлөвлөж, нарийн сайн тооцоолох хэрэгтэй. Үүн дээр л сэтгэл дутаад байна. Жишээ нь миний бие Чингис бондын мөнгийг үр ашиггүй зүйлд хөрөнгө оруулж байхаар Тавантолгойд хөрөнгө дутаад байгаа юм бол тэнд хөрөнгө оруулж болохгүй юм уу гэж саналаа хэлж л байлаа. Бүр болохгүй бол Оюутолгойд тийм их зээлийн өртэй суухын оронд зээлээ эртхэн төлж ч болох л байсан. Гэхдээ одооноос төр үр ашигтай төслийн эрэлд гарлаа. Эндээс харахад зөв зам руугаа явж байгаа юм болов уу даа. Гэхдээ энэ богинохон хугацаанд шинээр төсөл боловсруулна гэдэг хэцүү. Тиймээс шинээр төсөл боловсруулах биш, нэгэнт боловсруулчихсан бүр болдог бол хэрэгжээд эхэлсэн тийм төсөлд бондын мөнгийг өгөх хэрэгтэй. Би “Монголын алт” компанид ажиллаж байгаа. Тэнд хоёр ч том төсөл хэрэгжээд явж байна. Тухайлбал, нэг сая тонн цемент үйлдвэрлэх төслийн ТЭЗҮ бэлэн. Одоогоор тоног төхөөрөмжийн суурилуулалт бэлэн болчихсон. Барилгын ажил нь эхэлчихсэн. Энэ оны сүүл гэхэд ашиглалтад орохоор байгаа. Тиймээс ийм үндэсний компанийн томоохон төсөлд хөрөнгө оруулж болдоггүй юм уу. Ийм төсөл чинь бондын өрийг маш түргэн төлөх боломжийг бүрдүүлнэ. Ер нь бонд гаргаж байгаа бол дотоодын бизнесийн сайн компани Монголын төр хоёр харилцан уялдаатай л ажиллах хэрэгтэй.

Ш.Гунгаадорж: Монголчууд бондыг хэрхэн чулуу болгох ухаанаа олоогүй л байна. Хэрвээ байдал энэ чигээрээ яваад байвал хэдэн үеэрээ өртэй явах болно. Сая гэнэт ухаан оров уу гэлтэй импортыг орлох төсөл хайж эхэллээ. Одоо Чингис бондоос үлдсэн мөнгийг үр ашгаа түргэн өгөх төсөлд зарцуулах ёстой. Тэгэх байх гэж найдаж байна. Нөгөө талдаа Самурай бондын талаар их сайн судлахгүй бол горьгүй. Яагаад дэлхийн улс орнууд Самурай бондыг сонирхохгүй байна вэ. Франц нэг удаа орсон юм гэсэн. Тэгээд төдөлгүй больчихсон байдаг. Тиймээс Самурай бонд аваад, хавханд орчихож магадгүй гэдгийг анхааараасай. Хэрвээ судлаад бондоо авахаар болж байгаа бол аль болох дотоодын үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй. Монголд байгаа бэлэн зүйл бол бэлчээрийн мал аж ахуй. Энэ нь нэг ёсондоо мах үйлдвэрлэл гэсэн үг.

Ер нь хараад байхад өнөөгийн төр, засагт улс орноо хэрхэн хөгжүүлэх талаар дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө алга. Тийм болохоор нэг л төөрсөн бодлоготой хүмүүс яваад байна. Тиймгүйсэн бол өдийд уул уурхайгаа хэрхэн хөгжүүлэх, аль салбараа илүү дэмжих, бондын мөнгөө хаана зарцуулах вэ гээд бүх асуултын хариу гарчихсан байх учиртай. Гэтэл тэмтрүүлийн маягтай дайралдсаныг нь аваад л яваад байх шиг.

Д.Бямбасүрэн: Нефтийн жижиг үйлдвэр яагаад барьж болдоггүй юм бол



Д.Бямбасүрэн: Энэ бол их ноцтой асуудал. Шуудхан хэлэхэд бондын асуудалд өнөөгийн төр маш хариуцлагагүй хандлаа. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монголд хийж байгаа хөрөнгө оруулалтыг судалж үзэхэд нэмэгдсэн өртгөөрөө таван жилийн хугацаанд, ашгаар нь тооцвол 12 жилд нөхөгдөх тийм л хөрөнгө оруулалтыг хийж байгаа. Энэ бол маш муу хөрөнгө оруулалт гэж хэлж болно. Ийм нөхцөлд импортыг орлох валютын зардлыг хэмнэх чиглэлд бондын мөнгийг зарцуулах хэрэгтэй байсан юм. Тэр дундаа металлургийн үйлдвэрийг дэмжих. Мөн цемент, мах боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулсан бол хэдэн жилийн дараагаас

ХӨГЖИЖ БАЙНА ГЭЖ ЯРИАД ЯАХ ВЭ ДЭЭ”

валютын орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг багасгах эерэг нөлөөтэй байсан. Гэтэл одоогийн хөрөнгө оруулалтыг харахад бизнесийн чиглэлд хөрөнгө оруулаад байна. Энэ бол маш үр ашиггүй зарцуулалт. Мөн нөгөө талдаа төгрөгийн ханшийг тэтгэх, интервенц хийхэд ашиглаж байна. Самурай бонд ороод ирэхээр ам.долларын ханш суларна гээд л шуугиад байх юм. Ингэж зарцуулах нь бас л үр ашиггүй. Хэрвээ байдал цаашдаа ингэж явбал маш том хариуцлагын асуудал босч ирнэ.

-Монгол Улс “Атрын III” аяныг амжилттай хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд хоёрхон жилийн өмнө 100-200 мянган тонн улаан буудай экспортлох боломжтой тухай ярьж байсан. Гэтэл энэ онд 100 мянган тонн улаан буудай импортлох тухай хэрүүл тэмцэл болж байна. Та “Атрын III” аяны үйл явц, үр дүнг сайн мэдэх хүний хувьд энэ талаар ямар бодолтой байна вэ?

Ш.Гунгаадорж: Би хэлдэг юм “Төрийн бодлого зөв явж байвал тэнгэр бурхан хүртэл хардаг” гэж. Үүний нэг жишээ бол “Атрын III” аян. Газар тариалангийн үйлдвэрлэл уналтад орсонтой холбоотой нэг үе монголчууд тусламжийн өт хорхойтой будаа, гурил бишгүй идэж зовсон. Ингээд “Атрын III” аяны үр дүнд дотоодын үйлдвэрлэлийн эрүүл бүтээгдэхүүнээр хангагдаад явж байтал сүүлийн хоёр гурван жилд энэ талын бодлого сулрах янзтай болсон. Үүний нэг жишээ бол энэ жил 100 мянган тонн буудай импортлох талаар баахан маргаан дэгдэж байна. Хэрвээ үнэхээр ургац алдаж хүн ардаа тэжээж чадахааргүй болсон бол будаа тариа импортоор авалгүй л яах вэ. Түүхэндээ бид гурван удаа л 100 ба түүнээс дээш мянган тонн буудай гаднаас авсан байдаг юм. Гэтэл энэ жил заавал гаднаас авах шаардлага байна уу. 390 гаруй мянган тонн үр тариа авсан. Үүний 340 гаруй мянган тонн нь улаан буудай. Нөгөө талдаа монголчууд 240 мянган тонн гэдэг боловч 180 гаруй мянган тонн гурил хэрэглэдэг улс. Гэтэл одоо 200 мянган тонн буудай гурилын үйлдвэрүүдэд байна. Тэр чинь 140 гаруй мянган тонн гурил болно. Ингээд балансыг нь тооцож үзэхээр тийм их хэмжээний будаа импортоор авч яах гээд байгаа юм бол.

-Үүний цаана ямар ашиг сонирхол байна вэ?

-Хэрвээ ургац алдаад импортлох гэж байна гэвэл тэрүүн шиг худлаа юм байхгүй. Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, дарга нар нь өөр өөр юм яриад яваад байгаа. Нэг болохоор гурилын үйлдвэрүүд будаагүй болсон гэсэн. Энэ нь худлаа болохоор “Өө бид нөөцөд авах гэж байгаа” гэх юм. Ийм эргэлзээтэй юм яриад яваад байж болохгүй ээ. “Алтан тариа” үйлдвэр өөрийгөө будаагаар бүрэн хангаж чадна гээд байдаг. Гэтэл шинээр барьсан гурилын найман үйлдвэр будаагүй болсон юм гэнэ. Тэгвэл цаашдаа хувийн компаниуд 100 гурилын үйлдвэр баривал төр бариулчихаад дараа нь тэр үйлдвэр нь будаагүй гээд суугаад байх юм уу. Уг нь бол улсын нийт хэрэглээ хэд вэ. Түүнд таарсан үйлдвэрлэл явуулах нь мэргэжлийн яам, төрийн бодлого байх ёстой баймаар. Хэн дуртай нь үйлдвэр бариад, будаа хэрэгтэй гээд байвал энэ Монголын газар нутаг олон үйлдвэрлэлийг хангаж чадахгүй.

-Сүүлийн үед шатахуун болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах тал дээр Засгийн газар, Монголбанк хамтран ажиллаж байна. Энэ хэр үр дүнтэй арга хэмжээ вэ?

Д.Бямбасүрэн: Шатахууны асуудлыг аваад үзье. 2008 онд дэлхийн эдийн засгийн хямралын улмаас Монголын эдийн засаг сөхөрч байхад нийт шатахуун импортлогчид консорциум байгуулаад Ерөнхийлөгч, Ерөнхий сайд дээр орж байсан шүү дээ. Тухайн үед тэднээс та нар монополь болох гээд байгаа юм биш биз хэн ч асуугаагүй. Үр дүнд нь шатахууны үнэ дэлхийн зах зээлд унаж байсан ч манайд өссөөр ирсэн. Би өглөө бүр олон улсын мэдээллийн агентлагуудын мэдээ үздэг. Тэндээс харж байхад сүүлийн жилүүдэд шатахууны дэлхийн зах зээлийн үнэ нэг их хөдлөөгүй. Гэтэл манайд үнээ нэмэхээс аргагүй болсон гээд ярьж байна. Үүний цаад шалтгаан нь нөгөө л нефтийн хараат байдал шүү дээ. Нефть урагшаа гаргаж байхаар яагаад өөрсдөө үйлдвэр барихгүй байгаа юм бэ. Нэг сонин юм яриад байна. 2015 онд нэг сая тонн нефть олборлох үйлдвэр барина гэж. Гэтэл өнгөрсөн жил 1.5 сая тонн нефть гадагш нь гаргалаа. 300 мянган тонныг олборлосон ч гэсэн жижиг үйлдвэр яагаад барьж болдоггүй юм бэ. Яагаад нефтийн үйлдвэрээ Дарханд барих ёстой юм бэ. Дорнодоос олборлож байгаа шүү дээ. Сонин байгаа биз. Эндээс юу гэж дүгнэж болох вэ гэхээр улс төрийн бодлогод бизнесийн ашиг сонирхол хутгалдаад байгаа хэрэг юм. Ер нь төрийн бодлогод байгаа бизнесийн санаархал хүндрэл дээр хүндрэл, ядуурал дээр ядуурал нэмж байна. Дэлхий дээр эдийн засаг нь 10 гаруй хувиар өсч байхад ядуурал буурахгүй байгаа нь их ховор тохиолдол. Манайд л ийм дүр зураг байна.

Д.Содном: Бидний яриаг сонсож байгаа хүмүүс бодож магадгүй. Энэ гурав баахан л шүүмжлээд байх юм. Гарах гарцыг нь зааж өгсөнгүй гэж. Би яригдсан зүйлүүд дээр хэдэн гарц хэлье. Цэвэр агаарт өөрийн дураар явж, байгалиасаа хоол хүнсээ өөрөө олж иддэг бэлчээрийн монгол малын мах бол аз жаргалтай малын мах. Эмчилгээний ч чанартай. Ингэж үнэлэгдэж байгаа махыг экспортод гаргах хэрэгтэй биз дээ. Үүний тулд ганц л асуудал шийдэхэд болно. Бүх аймагт мал нядлах, мах боловсруулах олон улсын стандартад нийцсэн үйлдвэр байгуулах шаардлагатай. Мөн малчдаас малыг зах зээлийн дундаж ханшаар тухайн үйлдвэрт авдаг зохицуулалт байх учиртай. Ингэж чадвал малчид мөнгөжинө. Ажлын байр нэмэгдэнэ. Нөгөө талаар жилдээ 10-12 сая толгойгоор нядалж байгаа малын арьс, ширийг боловсруулж болно. Нэг үхрийн ширнээс хамгийн багадаа сайн чанарын 20 тэлээ гарна. Гаднын нөлөөллөөс гарах гээд байгаа л юм бол боловсруулах үйлдвэртэй болох учиртай. Газрын тосны хайгуулыг сайжруулмаар байна. Газрын тосны газар гэж бий. Тэр байгууллага бол газрын тос хайхад биш, газрын тос хайж байгаа нэгэндээ төлбөрийн болон бусад төрлийн дарамт үзүүлдэг газар болчихсон байна. Тухайлбал, гэрээ байгуулахад 300-500 мянган ам.доллар

БОНДЫН МӨНГӨНД ХОНОЦЫН МАЯГИЙН

нэхдэг. Байцаагч ажилласны зардлыг ч бас төлүүлнэ гээд бод доо. Цаашлаад газрын тосны мэргэжилтэн бэлтгэсний төлбөр гэж авна. Ямар нь мэдэгдэхгүй баахан татаас авдаг газар нэг бий. Гэтэл тэр татаас нь хуулинд байдаггүй. Товчхондоо энэ салбарт буруу харсан бодлого яваад байгаа юм. Үүнийхээ оронд олсон ашгаа хэрхэн хуваах вэ гэдгээ л тохирох хэрэгтэй баймаар. Түүнчлэн нүүрснээс метан хий, шатахуун боловсруулан гаргаж авах тал дээр анхаарах цаг болсон байх. Ийм гурван зүйлийг төрөөс хараад, дэмжиж чадвал эхний ээлжинд болчих гээд байгаа юм.

-Сүлийн үед бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт газар авлаа. Гэтэл цалин, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар ярьж байгаа ч бас л их, бага хэмжээгээр гээд маргаж эхэллээ. Хавтгайруулж биш юмаа гэхэд бага тэтгэвэр тэтгэмжтэй хэсгийн орлогыг нэмэгдүүлэхгүй л бол тэсэхэд бэрх болж байна. Энэ тал дээр ямар бодолтой явдаг вэ?

-Д.Бямбасүрэн: Сүүлийн таван жилд Монголын зах зээлд өргөн хэрэглээний барааны үнэ 61 хувиар өслөө.Тэгэхээр тогтмол тэтгэвэр авдаг иргэдийн амьдрал дагаад унана шүү дээ. Төгрөгийн болон барааны үнэ нь тогтвортой байдаг бол тэтгэвэр нэмэхгүй байж болно л доо. Гэтэл манайд энэ бодлого алдагдаад байна. Урин дулааны улиралд гаднаас барилгачид авч барилга бариулдаг. Тэднийг цалин хөлс болон материалаар хангаад ажиллуулахад жилд нэг тэрбум ам.доллар зарцуулж байна. Ямар хэрэг байна. Инфляцийг нэг оронтой тоонд барина гэж жил бүр баталдаг. Нефть импортлогчид гэхэд л хоорондоо үгсэн хуйвалдаад үнээ нэмдэг. Үүнд төрийн зохицуулалт хэрэгтэй.

Д.Содном: Саяхан өртөг өндөртэй дэлхийн улсуудын нийслэлд худалдаалж буй бараа бүтээгдэхүүний үнийг харьцуулсан үзүүлэлт хэвлэлд гарсан байна лээ. Үүнээс харахад, манай үнийн төвшин маш өндөр ажиглагдсан. Гэтэл ард иргэдийнх нь авч буй цалин, тэтгэвэр тэтгэмж бага байгаа. Тиймээс иргэдийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд арга хэмжээ авах ёстой. Тооцоо судалгаа муутайгаар энэ ажлыг хийвэл иргэдийн нуруун дээрх ачааг улам хүндрүүлж магадгүй. Төрийн өмчийн томоохон газрын хувьцааг үнэгүй хувьчилж, тэр замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ гэсэн зүйл ярьж байсан. Энэ буруу шүү. Сингапур, Малайзыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан хоёр хүний номыг би сая уншлаа. Тэд хувьцааг үнэгүй тараахын хор уршгийг бичсэн байна лээ. Ажил хөдөлмөр эрхлэхгүй, хувьцаанаас ашиг хүртэж, бэлэнчлэх сэтгэлгээнд байсан иргэд ямар ч чадваргүй болдог юм байна. Мөн бүх иргэдийн орлогыг адил болгоно гэдэг онол байдаггүй тухай тус номонд бичсэн байсан. Түүний оронд орлого нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах хэрэгтэй. Тиймээс төр засгийн зарим ажлыг шүүмжлэхээс аргагүй байна. Шүүмжлэл, сөрөг хүч хаана ч хэрэгтэй. Шүүмжлэлд дургүйцдэг хүн тоормозгүй машин барих дуртайтай адил юм.

-Оюутолгой болон Тавантолгойн эдийн засгийн хувь заяа хэрхэн эргэнэ гэж хардаг вэ?

Д.Содном: Оюутолгойн хувьд Монголын тал авах ёстой ашгаа олж чадахгүй юм биш үү гэх хардлага байгаа, магадгүй. Анх гэрээ байгуулахад урдчилсан ТЭЗҮ-ээр манайд гурван замаар Оюутолгойгоос олох ашгийн 50-53 хувь нь орж ирэхээр байсан.Тэр нь байгалийн нөөц ашигласны таван хувь. Нийт ашгийнх нь 25 хувиар орж ирэх ёстой татвар. 34 хувийн ногдол ашиг гурав нэгдээд борлуулалтын орлогоос өртгийг нь хассан нийт ашгаас нь монголчууд дээрх хэмжээний ашиг хүртэхээр гэрээ хийгдсэн. Гэрээ хийснээс хойш хувь нийлүүлэгчдийн нууц гэрээнээс одоо харахад байдал жаахан хүндхэн болчихоод байна. Цаашдаа ч ийм хандлага тасрахгүй байх аа. Явсаар байгаад сүүлдээ монголчуудад нөөц ашигласны таван хувь л орж ирэх болчих шиг. Ногдол ашиг болон нийт ашгийнх нь татвар бүрхэг болчихсон. Тэгэхээр яах вэ гэдэг байна. Гэрээ хийж байх үеийн ТЭЗҮ-ийн дагуу борлуулалтын орлогод нөгөө гурван татварын ногдох хэмжээг нийлүүлж тооцох. Мөн борлуулалтын орлогоос нийт ашгийн 53 хувь нь хэд байх ёстой юм бэ гэдгээ тогтоочих хэрэгтэй. Ингэчихвэл хөрөнгө оруулалт яаж хийх вэ энээ тэрээ гэсэн бүх асуудал шийдэгдчихнэ. Зүгээр л борлуулалтын орлогоос авах ашгаа л тодорхой болгочих.

-Тавантолгойн хувьд?

Тавантолгойн хувьд хоёр хөрш болон гуравдагч орны төлөөллийг хөрөнгө оруулагчаар сонгох хэрэгтэй. Тухайлбал, Орос, Хятад, Япон гэсэн гурван оронтой тус бүрт нь 16 хувиар хөрөнгө оруулалтыг нь шийдэх нь зөв. Энэ нь нийт дүнгээрээ 48 хувь болно. 52 хувь нь Монголынх гэсэн үг. Үүний цаад учир нь нэгэнт хоёр хөрш маань тодорхой хувийг эзэмшиж байгаа учраас тээвэрлэлтийн болон борлуулалтын үнэ нь ямар байх тал дээр тэд бодно. Зардал чирэгдэл, тээврийн зардалд хүссэн хүсээгүй анхаарч эхэлнэ.

Ш.Гунгаадорж: Тэр 34 хувиас татгалзчихвал яадаг юм бэ

Ш.Гунгаадорж: Оюутолгой нэлээд төвөгтэй болчихлоо. Эхэндээ ойлгомжтой байж байснаа явцын



дунд ойлгомжгүй зүйл олон гарчих шиг. Ер нь цаашдаа Оюутолгойн асуудлыг хүндрүүлээд байвал бидэнд л ашиггүй. Тиймээс аль болох гаднын хөрөнгө оруулагч болон манай улсын ашиг сонирхол хаанаа огтлолцох вэ гэдэгт эртхэн тохиролцох нь чухал. Миний бодлоор тэр 34 хувь гэдгээс татгалзчихвал яадаг юм бэ. Энэ бол миний л бодол шүү дээ. Ямар ч байсан Оюутолгойг бид орхиж болохгүй. Тавантолгойн хувьд бол гадаад дотоод олон хүчин зүйл бий. Тиймээс Содном даргын хэлсэн саналыг бас бодолцох

СЭТГЭЛГЭЭГЭЭР ХАНДАЖ ТААРАХГҮЙ

хэрэгтэй. Хувь эзэмшүүлэхдээ нэг хувийн ч зөрүү гаргаж болохгүй тэгвэл байдал дордоно.

Д.Бямбасүрэн: Хоёр толгойн хувьд олон зүйлийн тусгал гэж хэлж болно. 2005 оноос хойш л Оюутолгойг ярьсан. Гэтэл Монголын төр өөрийнхөө баялагт эзний ёсоор хандаж чадаагүй. Оюутолгойн өөрсдийнх нь интернетэд тавьсан мэдээллээс би хэд хэдэн тооцоо хийж үзлээ. Хэрвээ одоогийн ярьж байгаагаар бол баялгаа гаднынханд зүгээр өгөөд хариуд нь өртэй л үлдэнэ. Баялгаа хүнд өгчихөөд өөрөө өртэй үлдэхээр гэрээ хийдэг төр өнөөх ухаалгийн чинь эсрэг болчихоод байгаа биз дээ. Миний бодлоор Оюутолгойд ашиг сонирхлын зөрчил, шуналын бүх төрлийн нян цугласан болохоор ийм байдал үүссэн. Хэрвээ энэ гэрээг сайжруулах гэвэл Гунгаадорж гуайн эсвэл Содном гуайн хэлсэн аль аль саналаар нь явж болох л байсан. Товчхондоо асуудал хүнд байгаа. Цаашдаа ч хүндрэх төлөвтэй. Манайхан хэлэлцээрийн ширээний ард суучихсан. Тиймээс одоо Монголын тал худлаа дүнгэнэхээ болиод ярьж эхлэх хэрэгтэй.

Тавантолгой бол нүүрсний л уурхай шүү дээ. Монголчуудын хувьд ил, далд уурхайн аль алийг нь ашиглах боловсон хүчинтэй. Хөрөнгө мөнгөний л асуудал байсан. Боломж ч их байсан. Бондын мөнгөө хийж болох байлаа. Эсвэл түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр гэрээ хийгээд ашиглаж болох байсан. Гэтэл манай эрх мэдэлтнүүд хэд хэд хуваагаад бизнесийн хэрүүл болгож хувиргасан. Тиймээс Тавантолгойг нийгэм, дэд бүтэц гээд бүх талаас нь авч үзэх хэрэгтэй. Нэг л нүүрсний уурхай байх учиртай. Гэтэл одоо юу юу ч болгочихов. Анхнаас нь хоосон найдвар төрүүлж баахан бэлэн мөнгө, хувьцаа тараагаад. Ийм байдлаасаа эрх биш сургамж авсан байх гэж найдаж байна.

-Монгол Улсын Ерөнхийлөгч "Том төрөөс ухаалаг төр лүү" гэсэн уриалга гаргаж, тодорхой ажлуудыг хийж эхэллээ. Энэ ажлыг та бүхэн хэрхэн харж, дүгнэж байна вэ?

Д.Бямбасүрэн: -Энэ санаачилга монголчуудын хувь заяаг шийдэх ч зүйл байхыг үгүйсгэхгүй. Ухаалаг төр гээд ярихаар одоо ухаалаг биш байгаа юм уу гэсэн асуулт заавал дагалдаад байдаг юм. Миний бодоход төр холч бодлоготой байх ёстой. Бидэнд өнөөдөр хамгийн их үгүйлэгдэж байгаа зүйл нь энэ.Төр бол улс орны амьдралын зохицуулалтын төв нь юм. Гэтэл энэ төв хэрхэн зохицуулахаа мэдэхгүй бол хэцүүднэ шүү дээ. Үүнийг бид сүүлийн таван жилд гарсан эдийн засгийн хоёр удаагийн хямралаас харж болно. Төр шударга байвал ард түмэн төрдөө итгэнэ. Иргэд төрдөө итгэвэл бодлогын хүч нэмэгдэх учиртай. Би бичил судалгаа хийж үзлээ. Монголын насанд хүрсэн хүмүүсээс жилд 20 гаруй мянган хүн мөрдөн байцаалтад сэжиглэгдэж очдог юм байна. Үүнийг УИХ, Засгийн газрын гишүүдийн тоотой харьцуулахад маш сонин тоо гарна. Өөрөөр хэлбэл, нэг жилд хэрэгт сэжиглэгдэж байгаа улс төрийн удирдах албан тушаалтны тоо энгийн иргэдийнхээс 30 дахин их байна. Тэгэхээр бид хэнийг сонгочихоод байна вэ. Би мөнгөтэй хүн гээд улс төрийн намд хандив өгөөд УИХ-ын гишүүн болчихдог. Энэ тогтолцоог өөрчлөх ёстой. Өөрчлөхгүйгээр цаашаа явж чадахгүй.

Д.Содном: -Төр иргэн хоёрын харилцаа ухаалаг байх ёстой. Төр-бизнес хоёр яаж түншлэх, бизнесийг дэмжих ухаан төрөөс гарч байх ёстой. Энэ ухаалаг төрийн нэг анхаарах зүйл. Гэхдээ ухаалаг төр гэхээр л УИХ, Засгийн газрын хэдэн гишүүдийн үүрэг мэтээр ойлгож болохгүй. Ерөөсөө Монгол Улсын иргэн бүр, ялангуяа бүх төрийн албан хаагчид зөв ажиллаж чадвал ухаалаг төр сая бүрдэх учиртай. Тэр цагт Монгол орны хөгжил урагшилна.

Ш.Гунгаадорж: -Энэ сэдэв өмнө нь яригдаж байсан. Үүнийг Ерөнхийлөгч маань дахин сануулж байна. Төрийн бодлого ард түмнийхтэй уялдахгүй байгааг зохицуулах тухай юм.

-Та гурвыг нэг дор суулгаад ярилцлага авч байгаагийн хувьд асуухгүй өнгөрч болохгүй нэг сэдэв бол Монгол төрийн гадаад бодлогын тухай. Гадаад харилцаанд анхаарах хамгийн чухал зүйл нь юу вэ?

Д.Содном: -Гадаад харилцаанд бизнесүүдтэй харьцахдаа маш хянуур байх ётой. Манайх гадаадын хөрөнгө оруулалтыг их шүтэж байгаа өнөө үед эдийн засгийн алуурчид ороод ирж магадгүй шүү. Зарим нь хөлөө тавьсан байхыг ч үгүйсгэхгүй. Тиймээс энэ асуудалд болгоомжтой хандах нь чухал. Ерөнхийлөгч "Гадаадынхантай хийж байгаа гэрээнүүдэд сайд нар оролцоод байгаа нь буруу. Хуулийн, эдийн засгийн болоод бусад чиглэлийн бэлтгэгдсэн хүмүүсээр гэрээ хийлгэж бай" гэж хэлсэн байна лээ. Би үүнийг дэмжиж байгаа. Эдийн засгийн алуурчид мэргэжлийн хүн мэтээр орж ирэх нь бий. Тиймээс тэднээс байнга болгоомжлох ёстой. Үүнээс гадна бид хоёр хөрштэйгээ харьцахдаа маш ухаалаг хандахгүй бол болохгүй. Урд хөрштэй эдийн засгийн бүх талын харилцаа хөгжиж байна. Харин хойд хөршид ухаалаг бодлого баримтлахгүй бол болохгүй. Манай улсын экспортод гаргаж буй бүтээгдэхүүний таван хувь нь ОХУ руу гарч байгаа тоо бий. Гэтэл импортоор авч буй бүтээгдэхүүний 60-70 орчим хувь хойд хөршийнх. Тэр нь нефтийн бүтээгдэхүүн, цахилгаан. Энэ тал дээр эдийн засгийн харилцаагаа хэрхэн идэвхжүүлэх талаар төрийн ухаалаг бодлого үгүйлэгдэж байна. Төр засгийн удирдлагууд тус улсын удирдлагуудтай уулзаж, энэ талаар сайн ярилцах хэрэгтэй байх.

Ш.Гунгаадорж: -Бид хоёр хөршээ стратегийн адил тэгш бодлого явуулахгүй бол горьгүй. 1990 онд намайг Сайд нарын зөвлөлийн дарга байхад АНУ-аас Бэйкер манай улсад айлчилсан. Бид тэр үед танайхыг гурав дахь хөршөө болгоё гэсэн юм. Тэгэхэд "Тэр болно. Гэхдээ та нар хоёр хөршийнхөө хилийг давж гарсны дараа гурав дахь хөрштэй болно шүү дээ" гэж байсан. Бид өнгөрсөн хугацаанд хоёр хөрштэйгээ адил тэгш харилцахад дутуу анхаарсан зүйл бий байх. Үүнийг цаашид ямагт бодож явахгүй бол болохгүй.

Д.Бямбасүрэн: -ОХУ Монголын экспортын 1.3 хувийг эзэлж байна. Үүнээс харахад, хойд хөрштэй экспорт зогсонги байдалтай болж буй нь харагдана. Манайхан заримдаа хоёр их хөршөөр хязгаарлагдсан, далайд гарцгүй орон гэж ярьдаг. Энэ буруу ойлголт. Харин ч манайх дэлхийн хязгааргүй том зах зээлийн дунд оршиж буй орон. Хүн амын тоогоор Хятад, газар нутгийн хэмжээгээрээ



Mongolian Economy" сэтгүүлийн редакци. 2014.1.09

ОХУ нэгдүгээрт ордог. Эдийн засгийн чадавх ч сайтай. Тиймээс хоёр хөрштэйгээ эдийн засгийн харилцаагаа тэгш явуулж, ойлголцолд хүрвэл амжилтад хүрнэ гэдгийг хэлье. Үүнээс гадна би нэг зүйлийг нэмж хэлэхэд, бид гурван их соёл иргэншлийн уулзвар дээр байгаа улс. Хойд талд Оросоор дамжаад Христосын ертөнц байна. Урд талд Буддын ертөнц байдаг. Баруун талд Баян-Өлгийгөөр дамжаад лалын ертөнц бий. Энэ чинь манай гадаад харилцаанд ямар байр суурьтай байгаа юм бэ. Тиймээс энэ чиглэлээр харилцаа холбоогоо хөгжүүлэх хэрэгтэй. Гадаад харилцааны тал дээр эдийн засгийн бодлого нь жаахан асуудалтай л яваад байна. Ганцхан жишээ хэлье. Монголчууд 2011 онд нүүрсний экспортоо огцом нэмээд дэлхийн нүүрсний зах зээлийг эвдсэн. Тухайн үедээ их өсөлттэй сайхан л байсан байх өнөөдөр яаж байна. Бодох л учиртай. Одоо бид дэлхийн зэсийн зах зээлийг эвдэх гэж байна. Үүндээ ухаалаг хандаачээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг талуудтайгаа харилцаагаа сайжруулж, зохицуулалтаа боловсронгуй болгох хэрэгтэй.

-Хөгжлийн тухай их ярьж байна. Хөгжлийг бий болгоход юуг анхаарах вэ?

Д.Бямбасүрэн: -Манайхан хөгжлийн тухай яриад байгаа. Хөгжил өсөлт хоёроо ялгаж, салгамаар байна. Энэ бүгдээс Монголын эдийн засгийг дүгнэн харахад, өөрийн гэсэн хөдөлгүүргүй техник юм. Төрийн одоо явуулж буй бодлогыг харахад, Хятадад үйлдвэрлэсэн том тракторын хойноос зүүгдэж байгаа мэт харагдаж байна. Өөрөөр хэлбэл, өмнөд хөршийн эдийн засаг өсөөд байгаа. Хүний тракторын чиргүүл болж зүүгдэлгүй Монгол гэдэг айл өөрийн гэсэн хөдөлгүүртэй болох ёстой. Зэс, нефтиэ боловсруулж, металлургийн салбараа хөгжүүлмээр байна. Хөгжлийг хүний оюун ухаан, технологи авчирна. Бид түүхий эд экспортолж байна. Азийн орнуудад түүхий эдээ нийлүүлээд орхих бус оронд нь технологи авах бодлого байх ёстой. Ингэж байж манай улс хөгжинө. Иргэдийн сэтгэхүйг өөрчлөх хэрэгтэй. Бүтээгч чадвараасаа илүү сайхан амьдрах шуналыг дэвэргэж ирсэн. Үүнээс болоод бид өр зээл тавьж байна. Бүтээх чадварынхаа хэрээр амьдрах философийг нийгэмд төлөвшүүлэх ёстой. Хүнээс зээлсэн мөнгөөр сайхан амьдарна гэсэн жам хаана ч байхгүй. Өр тавьж өнөө маргаашаа аргацааж байгаа нь ирээдүйгээ идэж буйгаас өөрцгүй. Сүүлийн үед Монголд баялаг бүтээгчдээ хайрлая, дэмжье гэж их ярьж байна. Гаднынхны судалгаагаар Монголын насанд хүрсэн хүн амын 0.01 хувийг эзэлж буй эрх мэдэлтнүүд нь манай орны үндэсний баялгийн 7.6 хувийг эзэмшиж байна гэж гарсан байна. Тэд энэ баялгийг бүтээсэн болж таарч байна уу. Бид нэгэн гэгээнтний хэлсэн үгийг санах хэрэгтэй юм шиг. Энэ нь “Тэвний сүвээр тэмээг хөтөлж гаргах нь баян хүнийг бурхан болгохоос илүү хялбар” гэж. Баячуудын ашиг сонирхолд хөтлөгдсөн төрийн бодлого зөв явахгүй байгааг эргэж харах ёстой.

Ш.Гунгаадорж: -Манай улс хүнээ хөгжүүлэх тал дээр сүүлийн жилүүдэд анхаарч байна. Мэдлэг, боловсролтой хүн бүхэн сайн байдаггүй юм байна. Үүний цаана жинхэнэ хүн байх ёстой юм байна. Өөрөөр хэлбэл, хүмүүжилтэй, эх орноо хайрлах үзэл манайд дутмаг байгаа. Энэ үзлийг цэцэрлэгийн наснаас нь эхлэн заах ёстой. Улс орны өнөөдрийн болохгүй бүтэхгүй байгаа зарим нэг зүйл нь ганц хүнээс хамаарахгүй. Тиймээс Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах ёстой. 20 гаруй жилийн өмнөхөөс одоо тэс өөр болсон байна. Парламентыг сонгодог тогтолцоо руу оруулах цаг болсон. Дээд, доод хоёр танхимтай болох ёстой. Газар нутаг томтой, хүн ам цөөтэй хоёр том гүрний дунд оршиж буй манай орны хувьд ийм парламентын тогтолцоо хэрэгтэй. Үндэсний эв нэгдлийг хангахад энэ байдал маш чухал үүрэг гүйцэтгэнэ.

Содном: Манай ардчилсан засаглалын тухай асуудал. Азидаа төдийгүй дэлхийд ардчиллаар үлгэр жишээ болж байгаа. Энэ нь мэдээж сайн. Гэхдээ бид эргэж харахгүй бол болохгүй болжээ. Ардчиллаа зөв замаар хөгжүүлэхгүй бол дэг журамгүй байдал руу хэт орчих вий гэх болгоомжлол бий. Нөгөө талаар дэлхийн алдартай хүмүүс манайд ирэхдээ хэд хэдэн удаа хэлсэн. Тэр нь дүр эсгэсэн ардчилал маш аюултай гэж. Тэгвэл бид ямар ардчилалтай байна вэ. Дүр эсгээгүй байгаа. Энэ хэдэн зуун жилийн өмнө ардчилал, зах зээлд орсон улсын Ерөнхий сайд, Ерөнхийлөгчид юу гэж хэлж байна вэ гэхээр “Ардчилал хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ улс орны хөгжил дэвшилд сахилга дэг журам хэрэгтэй” гэдгийг айхтар анхааруулж хэлдэг. Тиймээс энэ ч гэсэн манайд хамаатай асуудал.

Д.Бямбасүрэн: -Содном дарга ардчиллын талаар хэлж байна. Ардчилал бол замбараагүй байдал биш ээ. Ардчилал гэдэг хэдэн бизнесмэнийг толгой дээрээ гаргах биш. Уг нь манай Үндсэн хуульд иргэний ардчилсан нийгмийг цогцлооно гэж заасан. Гэтэл сүүлийн үед зарим онолчид капитализм байгуулна гэсэн биз дээ. Одоо л тэднийгээ хамгаалах хэрэгтэй ухааны юм яриад байгаа. Энэ бол хүн төрөлхтний сэтгэхүйгээс 100 жил хоцрогдсон үзэл бодол. ■

ХЭТЭВЧ

ҮНИЙН ШУУРГАТАЙ ЦАГААН САР

С.А3

Ард иргэдийн амьдрал сайхан байна, бараа бүтээгдэхүүний үнэ өсөөгүй хэмээн том “тэнэгтдэг” төрийн түшээд мэр сэр бий. Гэвч бодит байдал дээр тэдний бодол 360 градус эргэчихээд байна. 2012 оны тавдугаар сард цалин, тэтгэврийг 30 хувиар нэмж байхад эдийн засгийн өсөлт 12.3 хувьтай байж. Гэтэл өнөөдөр өргөн хэрэглээний барааны үнэ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 30 хувиар өссөнийг илтгэх хөдөлгөөнгүй тоо баримт бий. Харин иргэдийнх нь орлого нэмэгдээгүй байсаар. Засгийн газраас цалин, тэтгэвэр нэмэх нь инфляци хөөрөгдөх хор урхагтай хэмээн үзэж, чимээгүйхэн нэмнэ гэх тайлбар хийж байсан. Үүнээс хойш жил гаруйн хугацаа өнгөрсөн ч ажил болон хэрэгжсэнгүй.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр өнгөрсөн сард инфляц 12.5 хувьтай гарч. Харин эдийн засгийн өсөлт 12 орчим хувьтай гарсан байна. Хэдийгээр эдийн засгийн өсөлт ийм байгаа ч бидний хэтэвч тэр хэрээр зузаарч, худалдан авах чадвар өссөнгүй. Сар шинийн баяр хаяанд тулсан энэ үед хэдийнэ тэнгэрт хадсан гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ иргэдийг бөөн дарамтад оруулж буй. Хэдхэн хоногийн өмнө монголчуудын гол хэрэглээний нэг болох гурилын үнэ 25 кг-тай нь дунджаар 16500 байсан. Одоо 20000-22000 төгрөгт хүрсэн байна. Тоолдог хэд нь тоотой учир үнийн өсөлтөд дарлуулсан иргэд бухимдахаас өөр аргагүй. 50 орчим сая толгой малтай Монголд мах магнаг болчихоод байгаа гэхэд хилсдэхгүй. Жил ирэх тусам махны үнэ өссөөр ирсэн нь энэ удаа ч давтагдаж байна. Нийслэлчүүдийн махны хэрэглээг хангадаг “Хүчит шонхор” худалдааны төвд нэг кг хонины цул мах 7500 төгрөг болжээ. Шинэ оны өмнөхөн 6800 төгрөг байсан. Гэтэл 10 гаруйхан хоногийн дараа 700-1000 орчим төгрөгөөр нэмэгдсэн байх жишээтэй. Үүнийг тус төвийн худалдагч нар сар шинийн баяртай холбон тайлбарлаж байна лээ. Баярын ширээний ууц шүүсээ бэлтгэхийн тулд бидний хэтэвчнээс багагүй мөнгө гарах нь. Гурилын үнэ нэмэгдсэн болохоор ул боов, еэвэнгийн үнэ ч өмнөх жилийн мөн үеийнхээс өссөн байсан. “Жилд ганцхан удаа болдог, бидний уламжлалт баяр юм даа” хэмээн манайхан Цагаан сараа байдгаа шавхан тэмдэглэдэг. Энэ удаагийн баярт иргэдийн сарын цалин хаанаа ч хүрэлцэхгүй нь бололтой.

/Өргөн хэрэглээний барааны үнэ нийслэлийн томоохон худалдааны төвүүдэд ямар үнэтэй байгааг хүснэгтээр харуулав/ ■

(Нэгдүгээр сарын 11-ний байдлаар)

Мах /кг.төгрөг/

Төрөл		Үнэ		
		Хүчит шонхор	“Бөмбөгөр”	“Миркури”
Үхэр	цул	8000-8500	8500-9000	9000-11000
	Ястай	7500-8000	7500-8500	8500-10000
Хонь	цул	6300-7200	7000-7500	7200-8000
	ястай	6200-6500	6300-7000	6500-7200
Ямаа	цул	5800-6200	6000-6500	6500-7000
	Ястай	5200-5500	5500-6000	5800-6500
Тахиа	мөч	5000-5500	5200-5500	6000-6500
	гуя	4800-5500	5000-5500	5500-6000
Адуу	цул	5000-5500	5200-6000	5500-6500
	ястай	4500-5000	4700-5500	5000-6000

Бусад бараа бүтээгдэхүүний үнэ

Ургамлын тос	3000-3500	3200-3500	3500-4000
Элсэн чихэр	1600-2000	1800-2000	2000-2500
Цагаан будаа	1800-2000	2000-2200	2000-2500
Гурвалжин будаа	1500-2000	1800-2000	2000-2500
Давс	600-1000	500-800	500-1000

Хүнсний ногоо /кг.төгрөг/

Монгол төмс	600-800	650-800	700-900
Монгол лууван	1000-1200	1000-1100	1200-1500
Монгол сонгино	1300-1500	1500	1500
Монгол манжин	1000-1200	1200-1500	1300-1800
Монгол байцаа	1200-1500	1200	1500-1800
Сармис	3500-4000	3000-4500	4000
Цагаан лууван	2000-2500		2500-3000

Гурил /кг.төгрөг/

		10 кг	25 кг	10 кг	25 кг	10 кг	25 кг
Улаанбаатар	дээд	12000	20000	12500	19500	13500	22500
Алтантариа	дээд	11000	25000	11500	24500	12000	26000
	I	8000	18500	8500	19000	9000	21000
	II	5000	9500	5500	10000	6000	11000
"Атар"	дээд	11500	26000	11000	25500	12500	26500
	I	8000	18500	8000	18000	9000	19000

БОДЛОГО, ШИЙДВЭР

ТӨРӨӨС БАРИМТЛАХ ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО

С.АНИР

Газрын доорх баялгаараа дэлхий дахинд “моодонд” орж буй манай орны хувьд энэ салбарт төрөөс баримтлах бодлого зайлшгүй хэрэгтэй байгаа. Монгол Улсын эдийн засгийн чадавх, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ тухайн жилд хэд байх нь уул уурхайн бүтээгдэхүүнээс бүрэн хамааралтай болсон. Тиймээс төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж буй билээ. Монголын төр 2013-2024 он хүртэл уул уурхайн салбарт ямар бодлого барьж ажиллахаа энэ удаагийн баримт бичгээр баталгаажуулах юм. Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, уул уурхайн компаниудад үйл ажиллагаа явуулах чиг баримжааг бүрдүүлэхээрээ тус бодлого бидэнд чухал ач холбогдолтой.

УИХ-аас баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008), “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” (2010) зэрэг суурь бичиг баримтад эрдэс баялгийн салбарын хөгжилд төрөөс баримтлах бодлогын зорилго, зорилтын талаар тусгаж иржээ. Харин одоо тусгайлсан бодлого гаргах нь манайд олон талын ач холбогдолтой хэмээн эх баригчид үзэж байна. УИХ-ын хаврын чуулганаас эхлэн он дамжин хэлэлцэж буй уг бодлогын баримт бичиг энэ долоо хоногт (нэгдүгээр сарын 6-11-н) батлагдах байв. Харамсалтай нь, УИХ дахь МАН-ын бүлэг уг бодлогын баримт бичигт эргэж харах, засч залруулах зүйл байна гэж үзсэн учир завсарлага аваад буй юм. Тэд МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлэгтэй адил байр



суурьтай байгаагааг илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл, тухайн ордын анхны үнэлэмжийн тогтоох ёстой гэж үзжээ.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, чиглэл, зохицуулалт, удирдлагын тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох. Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны, дэд хөтөлбөрөөс бүрдэж буй аж. Баримт бичигт эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулагчид нь хууль дээдлэх, харилцан ашигтай ажиллах, компанийн засаглалыг дэмжих зүйл заалт тусгагджээ. Мөн төрөөс өмчийн хэлбэр болон хөрөнгө оруулагчийг ялгаварлахгүй байхыг зааж өгсөн байна. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг батлагдах аваас дараах зүйл заалтыг мөрдөнө.

3.1.3. Ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлэх (аж ахуйн нэгжийг худалдан авах, компанийн хяналтын хувьцааг авсан) бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбай, ордын эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, хариуцсан төрийн байгууллагад мэдэгдэж, тогтоосон хэмжээний татвар төлж байх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.1.4. Алтны олборлолт, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын үйл ажиллагаанд ил тод байдлыг бүрдүүлэхэд холбогдох хууль, тогтоомжийг боловсронгуй болгох.

3.1.7. Ордыг иж бүрнээр судлах, үнэлэх, дагалдах эрдсийг ялгаж авах шаардлагыг хуульчлан нэвтрүүлж хэрэгжүүлэх.

3.1.11. Баялгийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж, эдийн засгийн үр өгөөжийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бий болгох.

3.4.1. Эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж нэмүү өртөг шингэсэн цэвэр катодын зэс, төмөр хийц, ураны шар нунтаг, цэвэршүүлсэн алт, газрын ховор элементийн баяжмал зэрэг бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрүүдийг бодлогоор дэмжих.

3.4.2.Нүүрсийг баяжуулах, кокс, химийн үйлдвэр байгуулах, эрчим хүчний нүүрсний ордууд дээр цахилгаан станц барих ,хүрэн нүүрснээс утаагүй түлш, нүүрс болон шатдаг занараас шингэн түлш гарган авах, нүүрсийг хийжүүлэн байгалийн ойролцоо түвшний чанартай хийг гаргах зэрэг төслийг хэрэгжүүлэх.

3.4.3.Боловсруулах үйлдвэрийн чиглэлд байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд халгүй орчин үеийн, шинэ техник, технологи, инновацийг дэмжих. »

3.4.4. Төрөөс боловсруулах үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжиж ашигт малтмалын боловсруулалтын түвшингдээшлүүлэх.

3.5.2. 1,5 хувиас дээш хүхрийн агуулгатай нүүрсний ордыг шинээр нээхийг хязгаарлаж, 3 хувиас дээш хүхрийн агуулгатай нүүрсний ордыг шинээр нээхийг хориглох.

3.6.4. Эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, өндөр үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтоох, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах. Монголын эрдэс баялгийн бирж байгуулах;

3.6.11. Ашигт малтмалыг түүхий хэлбэрээр экспортлох явдлыг үе шаттайгаар бууруулж, нэмүү өртөг шингэсэн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих. Олон улсын зах зээлийн үнээр борлуулах боломжийг бүрдүүлж, эрдэс баялгийн салбараас орох орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцох арга аргачлалыг боловсронгуй болгох;

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд “Улсын геологийн зураглал”, “Нүүрс”, “Төмөр”, “Хайлуур жонш”, “Газрын ховор элемент”, “Зэс”, “Барилгын ашигт малтмал” “Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчин” зэрэг хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Эдгээр хөтөлбөрийг боловсруулахад шинжлэх ухааны байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодыг татан оролцуулах аж. ■

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

“ХҮРЭН” МОНГОЛ

Э.ТАМИР

Өдгөө хүрэн эдийн засаг “гологдож” байна. Алсдаа бүр ч явцгүй. 2050 оноос дэлхийн хүн ам 9.1 тэрбумд хүрч, хүнсний хэрэгцээ 70 хувиар нэмэгдэж, дэлхий дахиад хүнсний дайн дэгдэж магадгүй гэдгийг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага судалсан байна. Тиймээс дэлхий нийт ногоон эдийн засагтай болохоор зориг шулуудсан. Тухайлбал, Хятад улс ногоон эдийн засагтай болсноор жилд нэг их наяд ам.долларын орлого олох боломжтой. Таамаглалаар 2015 онд тус улсын ногоон эдийн засгаас олсон орлого ДНБ-ий 15 хувьтай тэнцэх гэнэ. Харин Орос улс 2020 он гэхэд эдийн засагтаа нvvрстөрөгчийн хамаарлыг 40-45 хувь бууруулах зорилт тавьжээ. Харин монголчууд хаана явна вэ. УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей “Манайх хүрэн эдийн засагтай улс. Түүхий эд байгалийн нөөцийг ашиглахад тулгуурласан, их хэмжээний хаягдал гаргадаг, байгаль орчинд халтай үйлдвэрлэл үйлчилгээ л давамгайлж байна” гэж шуудхан хэлсэн. Уг нь “Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд заасны дагуу “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөр” буюу “Таван 20”-ийг боловсруулаад удаж байна. 2020 он дуустал хэрэгжих уг хөтөлбөрийн үндсэн зорилго нь: Эрчим хүчний үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлэх. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг суурилагдсан чадлын 20 хувьд хүргэх. Хүлэмжийн хийн ялгарлыг 20 хувиар бууруулах. Байгальд оруулах хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх. “Ногоон худалдан авалт”-ыг Засгийн газар, орон нутгийн төсвийн нийт худалдан авалтын 20 хувьд хүргэхэд чиглэсэн. Гэтэл энэ том зорилгын сураг ажиг таг чиг. Сэргээгдэх эрчим хүчний тухайд аваад үзэхэд өнгөрсөн онд хувийн хэвшлийн хүчээр боссон 50 мВт-ын Салхитын салхин цахилгаан станц. Өмнөх засгийн үед хэрэгжиж дууссан “100 мянган нарны гэрэл” төсөл зэргийг эс тооцвол өөр бодит үр дүн алга. Төрөөс сэргээгдэх эрчим хүчний салбарыг дэмжиж байгаа гэх боловч хөрөнгө мөнгө “уусан” дэмий зүйл болоод дуусах нь бий. Тухайлбал, усан цахилгаан станцтай болох гэж хэд хэдэн удаа оролдсон боловч бүтээгүй. Бүтээн байгуулалт хийсэн зарим нь “төмрийн хог” болохдоо тулсан гэдэг. Нөгөө талдаа уламжлалт эрчим хүчний салбар “амь тавих” дээрээ тулчихаад байгаа. Хэдийгээр өнгөрсөн оны наймдугаар сарын 1-нээс үнэ нэмсэн. Мөн тодорхой хэмнэлтүүдийг хийж эхэлсэн ч Монгол Улс хэтдээ эрчим хүчний дутагдалд ороходоо тулсан талаар доктор Г.Пүрэвдорж хэлжээ. “ДЦС-5”-ыг барихаар төлөвлөсөн ч хэзээ ашиглалтад орох нь тодорхойгүй хэвээр. Дээрээс нь өнгөрсөн онд эрчим хүчний салбарын алдагдал 80 орчим тэрбум төгрөгт хүрсэн. Үүнээс өмнө алдагдлын хэмжээ дунджаар жилд 40-43 тэрбум төгрөгт хүрч байжээ. Энэ мэт ногоон эдийн засгийг тодорхойлдог салбаруудын муу үзүүлэлт олон. Эндээс харахад одоогоор Монголд ганц байгаа гэж хэлж болох ногоон хөгжлийн талаарх баримт бичиг нь ийнхүү ажил хэрэг болохгүй байна. Хүрэн эдийн засгаараа ч гурван сая хүрэхгүй иргэн нь хүний дайтай амьдарч чадахгүй байгаа Монгол Улс хэзээ ногоон хөгжилд жинхэнэ утгаараа хөл тавих юм бол. ■



ХӨРШ

ШИНЭ ЭХЛЭЛ

Б.ТОГТОХ

Урд хөрш өөрчлөгдөж байна. Өөр болох гэж үзэж байна. Эрс шинэчлэлд тэмүүлж байна. Энэхүү өөрчлөлт нь бизнесийн эрх чөлөөнд хөтлөх бололтой. Си Зиньпин тэргүүтэй Хятадын тав дахь үеийн удирдагчид өнгөрсөн оны сүүлийн саруудад 2020 он хүртлэх бодлого, стратегиа тодорхойлж, “замын зураг”-аа дэлгэлээ. Төр баригч Хятадын Коммунист Нам /ХКН/ -ын Төв хороо /ТХ/-ны 18 дахь удаагийн III бүгд хурлаас нийгмийн бүхий л салбарыг хамарсан чухал тогтоол гаргалаа. Энэ нь Хятадын шинэ удирдлага шинэтгэл, нээлттэй бодлогоо тууштай үргэлжлүүлэх улс төрийн саадыг арилгав. Ингэснээр шинэчлэлийн бодлогоор улс орныхоо тогтвортой хөгжлийг зангидах Си Зиньпин эрх мэдлээ илүү баталгаажууллаа. Түүний тодорхойлж буй “Хятад мөрөөдөл” биелэлээ олох нь.

“Бид өмнөд хөршөө, түүний дотор шинэ удирдлагын зүгээс дотоод, гадаад бодлогын талаар дэвшүүлж буй зорилго, зорилтуудыг ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, өргөн хүрээнд хамтран ажиллах гэж буй, худалдаа наймаа хийх гэж буй түншээ таньж мэдэхгүйгээр харилцан ашигтай хамтран ажиллахад хэцүү” болохыг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор Д.Шүрхүү хэлсэн юм. Шинэ оны өмнөхөн “БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлт: Монгол-Хятадын харилцааг хөгжүүлэх шинэ боломж” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал Улаанбаатар хотноо болсон юм. Энэ үеэр дээрх шинэчлэл, нээлттэй бодлогын талаар түлхүү хөндсөн билээ.

БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлого гүнзгийрэх шатандаа орж байгаа нь хөрш зэргэлдээ манай улсын хувьд чухал үйл явдлын нэг юм. Хөршийн тогтвортой хөгжил манай улсын хөгжилд, тухайлбал, эдийн засагт шууд нөлөөтэй болохыг бид мэдэрсээр суугаа. Энэ онд манайх 31.4 сая тонн нүүрс урд хөршид экспортолно. Энэ бол Хятадын импортын нүүрсний өчүүхэн бага хэсэг.



Гол нь сонголт хийх боломж бидэнд бус урд хөршийн талд хэлбийж байгаа нь бизнест төдийгүй төсөвт эрсдэл дагуулсаар.

Шинэтгэлийг гүнзгийрүүлэх явдлыг ХКН-ын ТХ-ны III бүгд хурлын шийдвэрт түүхэн шинэ эхлэл хэмээн тодорхойлсон. Энэ нь Хятадын энэ удаагийн өөрчлөлтийн бодлогын цар хүрээ нь тэдний хөгжилд ямар их ач холбогдолтой болохыг харуулж буй. Нөгөөтэйгүүр маш хүнд эрсдэлтэй үйл явц гэдгийг тус хурлын шийдвэрт “бэрхшээлийг даван туулах цаг үе тулгараад байна” гэж цохон тэмдэглэснээс харж болох юм.

Хятадын энэ өөрчлөлт шинэтгэлийн бодлогын нэг онцлог нь эдийн засгийн хөгжлийн загварыг нэлээд ул суурьтай өөрчилж байгаад оршиж буй. Өөрөөр хэлбэл, гадаад зах зээлд бус дотоодын зах зээлд түшиглэхийн сацуу Хятад хүн бүрийн хэрэглээнд тулгуурлахыг тэд илүүд үзэв. Магадгүй энэхүү эдийн засгийн бүтцийн хөдөлгөөн нь далайцаараа дэлхийн эдийн засагт ч нөлөөлж мэдэх юм.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд БНХАУ хямд ажиллах хүч, гадаадын хөрөнгө оруулалтад тулгуурлан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, экспортод найдаж хөгжиж байлаа. Тэгвэл АНУ, Европ дахь эдийн засаг, санхүүгийн хямрал, гадаад зах зээлийн хумигдал нь явцуу болохыг тэд сая ойлгов. Үүнээс гадна хэт үйлдвэрлэлээс улбаалсан байгаль орчны бохирдол, нийгмийн зөрчил хурцадсан зэрэг нь өмнөх хөгжлийн загвар явцгүй болсныг тод харуулах болсон. Иймд асар том дотоод зах зээл, инновац, өндөр технологийн үйлдвэрлэлийг баримжаалсан шинэ хөгжлийн загварт шилжих нь зүйтэй гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлээд

байна. Ингэснээр барууны хэв маягийг шигтгэсэн, тогтвортой төдийгүй ногоон хөгжил өөд зүтгэсэн цогц шинэчлэл хийх үе шатанд БНХАУ ийн шилжлээ. Өөрөөр хэлбэл, Хятадын улс төрийн бодлогын шинэчлэл эдийн засгийн хөгжилд нь шинэ он тооллыг эхлүүлж байна.

ХКН-ын ТХ-ны III бүгд хурлын шийдвэрийн долдугаар хэсэг буюу “Нээлттэй эдийн засгийн шинэ механизмыг байгуулах” гэсэн хэсэгт бидний анхаарлыг татахуйц чухал заалтууд оржээ. Нээлттэй бодлогоор шинэчлэл өөрчлөлтийг урагш түлхэх нь заалтын гол агуулга аж. Хятадын Засгийн газрын зүгээс гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын тогтвортой, ил тод байдлыг хангаж, гадаадын хөрөнгө оруулалтад тавьсан хязгаарлалт улам бүр багасах.

Мөн Хятадаас гадаадад хөрөнгө оруулах явдлыг дэмжих юм байна. Тухайлбал, гадаадад хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж болон хувь хүний статусыг өргөх, компаниудыг нэгтгэн нийлүүлэх замаар аж ахуйн нэгж байгуулах. Үнэт цаас худалдан авах замаар болон бусад хөрөнгө оруулагчидтай хамтрахыг зөвшөөрнө гэж дээрх шийдвэрт заажээ. Төрийн өмч зонхилсон Хятадад бизнесийн талбар дахь эл өөрчлөлт өргөн боломжийг дуудсаар. Ингэснээр Хятадад манай улсын иргэд, аж ахуйн нэгж хөрөнгө оруулах боломж нэмэгдэнэ гэсэн үг.

Өмнөд хөрш өндөр зэрэглэлийн чөлөөт худалдааны бүсийн сүлжээг байгуулах. Түүний дотор хил орчмын нээлттэй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар Хятад бэлтгэж байна. Хил орчмын улс орон бүс нутгуудтай харилцан саадгүй нэвтрэлцэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг шуурхайлахаар зэхжээ. Хятадад бизнесийн илүү таатай, тааламжтай орчинг бүрдүүлсээр. Үүнийг эдийн засгийн хувьд жинхэнэ ардчилал болохыг тэмдэглэж буй. Гэхдээ энэ бол улс төрийн дэглэмээ нураана гэсэн үг биш юм. Харин эдийн засгийн бодлогоо эргэж харахын сацуу зөөллөж буй шинж болохыг судлаачид онцолж байна.

БНХАУ манай улсын экспортын 92 хувийг эзэлдэг. Харин манайх өмнөд хөршийн импортын өчүүхэн бага хувийг бүрдүүлсээр 2014 онтой золголоо. Хятадын нүүрсний импорт өнгөрсөн онд өссөн ч Монголын экспорт эрс буурсан. БНХАУ-ын хувьд хамгийн хямд үнээр, их хэмжээгээр түүхий эд авах сонирхолтой. Бидний хувьд эрдэс түүхий эдээ гүн боловсруулж өндөр үнээр борлуулах чин хүсэлтэй. Гэвч худалдаа, хөрөнгө оруулалтын бүтцийн өөрчлөгдөл байдал, дэд бүтцийн хоцрогдол, улс төрийн бодлогын нийцэл гээд цөөнгүй шалтгаанаас үүдэн дэргэд хэрнээ манай хоёр орны эдийн засгийн харилцаа зарим талаараа холдож буйг мэргэжлийн зарим хүн онцлон тэмдэглэдэг. Юутай ч БНХАУ-д шинэтгэл, нээлттэй бодлого гүнзгийрэх тусам өмнөд хөрш улам нээлттэй, зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явц улам түргэсэх нь лавтай. Энэ нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд шинэ боломжийг авчирна хэмээн манай судлаач, шинжээчид таамаглаж байна. ■

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

АМ.ДОЛЛАРЫН ЗАНГА

Орчуулсан Р.ГАНТУЛГА

Ам.долларын ханш буурч байна. Дэлхийд тэргүүлэгч энэхүү валютын хувьд дэлхийн санхүүгийн хямралаас хойш нэлээд зүйл үзсэн гэж болно. Логик талаас нь харвал, АНУ олон эдэдрээтэй асуудалтай тулгараад буй. Үүнд, өсөн нэмэгдэж буй улсын өр, Холбооны нөөцийн банкнаас хэрэгжүүлж буй уламжлалт бус мөнгөний бодлогоос үүдэх эрсдэл, улс төрийн асуудал гэх мэт багтана. Эдгээр хүчин зүйл нь ам.долларын үнэ цэнэд сөргөөр нөлөөлж, улмаар эдийн засгийн өсөлтийг нь бууруулна гэсэн хүлээлт ч бий.

Санхүүгийн хямрал нь ам.долларын эзлэх байр суурийг дордуулах биш, харин ч эсрэгээрээ улам хүчирхэгжүүлсэн байна. Учир нь ам.доллар дэлхийд хамгийн чухалд тооцогдох валютын нөөц юм. Олон улсын валютын зах зээлд гүйцэтгэдэг гол зуучийн үүрэг нь цаг хугацааны явцад буурах магадлалтай нь үнэн. Өнөөгийн санхүүгийн зах зээл, технологийн хөгжил нь улс хоорондын гүйлгээг ам.долларааас өөр валютаар хийх боломжийг бүрдүүлж буй. Гэхдээ санхүүгийн аливаа хөрөнгийг үнэлэхэд, ялангуяа АНУ-ын Засгийн газрын бондыг гаргахад ам.долларыг л хэрэглэдэг. Ам.доллар нь хөрөнгө оруулалтаа ашуулгүй байлгахыг эрхэмлэдэг хөрөнгө оруулагчдын хувьд бусдаас илүүд үздэг валют хэвээр аж.

Тэгвэл ам.долларыг дэлхий санхүүд эзлэх байр суурыа улам хүчирхэг болгоход нь санхүүгийн хямрал хэрхэн нөлөөлсөн байж таарах вэ? Гэтэл санхүүгийн хямралын голомт нь АНУ байсан шүү дээ. Үүнийг эрсдэлгүй хөрөнгийн эрэлт, хэрэгцээтэй холбон тайлбарлаж байгаа аж. Бусад оронд буурах болсон хангамжийг энэхүү эрэлтээр нэмэгдүүлсэн байна. Ийм арга замаар АНУ өөрөө ам.долларын



гол нийлүүлэгч нь болжээ. Шинээр гарч ирж буй орнууд хөрөнгийн тогтворгүй урсгал үүсэхээс урьдчилан сэргийлж, гадаад валютын нөөц хуримтлуулах зорилгоор ам.долларыг их хэмжээгээр худалдан авах болжээ. Нөгөө талаас, санхүүгийн зохицуулалтад хийгдэж буй реформ нь эрэлтийг мөн нэмэгдүүлсэн байна. Төвбанкуудын хувьд бэлэн мөнгөний урсгалын эрэлт, хэрэгцээг хангахын тулд хөрвөх чадвар сайтай, хангалттай нөөцтэй байх шаардлагатай байдаг аж.

Тэгвэл ам.долларыг орлох ямар валют байгаа юм бэ? Энэ асуулт гарч ирэх үед ам.долларын үнэ цэнэ ирээдүйд дордохгүй гэдэг нь харагдаж болох юм. Тухайлбал, Евро бүс, Япон, Их Британи зэрэг голлох эдийн засаг бүхий орнуудын Засгийн газраас гаргасан бондыг аваад үзье л дээ. Санхүүгийн хямралаас хойш эдгээр бонд нь нэлээд ганхаж, сульдсан нь харагдаж байна. Түүнчлэн Япон, Швейцарь зэрэг улсын Төвбанкууд өөрсдийн валютын ханшийг сулруулах зорилгоор уламжлалт бус мөнгөний бодлого хэрэгжүүлж буй. Валютын ханшаа өсгөхгүйн тулд эдгээр Төвбанк валютын зах зээлд хөндлөнгөөс шууд оролцох болсон. Гэтэл эрсдэлгүй хөрөнгийн тусын тулд дэлхийн бусад орны эрэлт, хэрэгцээнд тохируулан үйлчлэх учиртай баймаарсан.

Энэхүү ”Ам.долларын занга” гэж нэрийдэх болсон зүйлийг зарим эдийн засагч дэлхийн эдийн засагт томоохон эрсдэлийг дагуулах тэнцвэргүй байдал гэж үзэж байна. Ам.долларыг уналтад оруулах магадлалтай янз бүрийн хувилбар ч бий. Гэхдээ аль ч хувилбар нь дэлхийн улс, орнуудын эдийн засагт тодорхой хэмжээгээр нөлөөлөх аж. Уг нөлөөллийн үр дагавар нь харин ч эсрэгээрээ тогтворжилтыг авчирч ч болох талтай юм байна.

Дээрх асуудал нь бизнес эрхлэгчдэд ялангуяа үндэстэн дамнасан корпораци, санхүүгийн байгууллагад чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Менежерүүдийн хувьд худалдаа, санхүүгийн гүйлгээг ам.долларааас өөр валютаар хийх нь улам ихэснэ гэсэн хүлээлттэй байхад буруудахгүй. Тухайлбал, Хятадын юань олон улсын төлбөр, тооцоо хийдэг валют болж байгааг бид бэлээхэн харж байгаа шүү дээ.

Хөрөнгийн урсгал нэмэгдэж, валютын ханш ихээр хэлбэлзэх болсонтой холбоотойгоор олон төрлийн валют гарч ирэх явдлыг хязгаарлах шаардлага гарах нь. Мөн шинээр гарч ирж буй орнуудын валюттай харьцах ам.долларын ханш дахиад буурах нь ч тодорхой. Учир нь АНУ болон бусад орны эдийн засгийн үйлдвэрлэлийн гарц, бүтээмж зэргийн хооронд ихээхэн ялгаа байдагтай холбоотой.

Гэхдээ ам.долларын нэр хүнд унах вий гэж санаа зовох шаардлагагүй юм байна. Энэхүү валют цаашид урт удаан хугацаанд өөрийн давамгай байдлаа хадгалах болно гэсэн найдвар байгаа аж.

Эх сурвалж:
Harvard Business Review сэтгүүл

БАРИЛГА

УНАЛТААС СОРИЛТ ӨӨД

Б.БАЯРТОГТОХ

Эдийн засаг хүндэн жилүүдэд уналтад ороод байсан барилгын салбар өнөөдөр хөл дээрээ бүрэн зогсчээ. Үүнийг нотлох тоо баримт, судалгаа цөөнгүй. Нийслэл улам л барилгажиж байна. Барилгын салбар дангаараа манай улсын ДНБ-ий 10 орчим хувийг бүрдүүлж буй. Тус салбарын өсөлт өнгөрсөн оны эдийн засагт тулах цэг болжээ. “2013 онд барилгын салбар өмнөх жилтэй харьцуулахад 125 хувийн өсөлт үзүүлсэн. Мөн барилгын материал үйлдвэрлэгч компаниудын хувьд дийлэнх нь импортын бараг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн” хэмээн Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал хэллээ.

“Манай улсын хувьд өнгөрсөн оны эхний хагас жилд нийт 355.2 тэрбум төгрөгийн барилгын ажил гүйцэтгэсэн байна. Энэ нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 153 хувиар өссөн үзүүлэлт юм” хэмээн Монголын санхүүгийн зах зээлийн холбооноос гаргасан “Барилгын салбарын 2014 оны төлөв байдал” тойм судалгаанд дурджээ.

Монголбанкны зүгээс орон сууцны тогтвортой тогтолцоог хөгжүүлэхээр ипотекийн найман хувийн зээлийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж, эхэлсэн. Мөн барилгын салбарыг дэмжих, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зээлийн “коридор”-ыг арилжааны банкуудаар дамжуулан нээсэн. Тэр нь салбарын өсөлтөд хөшүүрэг болсныг Барилга, хот байгуулалтын дэд сайд Г.Байгалмаа онцлов. Төв банкны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд нийт 292.1 тэрбум төгрөгийн зээлийг банкуудаар дамжуулан барилгын компаниудад олгожээ.

Ажлын байранд тулгуурласан моргейжийн шинэ тогтолцоог ийн нэвтрүүлсэн нь зах зээлд “үнийн хөөс” үүсгэсэн болохыг зарим эдийн засагч учирлаж буй. Гэхдээ тус салбарын тогтвортой хөгжилд тэдийгүй гэр хорооллыг орон сууцжуулахад бодитой үр дүнгээ өгч байгааг дараах тооноос харж болох юм. Өнгөрсөн

оны арванхоёрдугаар сарын 30-ны байдлаар арилжааны банкууд шинээр 12803 иргэнд 739.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг шийджээ.

Барилгын салбар 2018 он хүртэл жилд дунджаар 200-400 тэрбум төгрөгөөр тэлэх судалгааг “Мастер пропертис” компаниас хийсэн. Мөн нийслэлд жилдээ 10-12 мянган айлын орон сууц барих боломж байгааг дээрх судалгаанд дурджээ. Эрэлтийн хувьд нийслэлийн 240 мянган өрхөд орчин үеийн стандарт орон сууц шаардлагатай байгаа. Тиймээс эрэлт мөддөө ханахгүй гэсэн үг.

Улсын хэмжээнд импортын нийт ачаа эргэлтийн гуравны нэг нь барилгын салбарт ногдож байгааг судалгаагаар тогтоосон. Мөн арилжааны банкны нийт зээлийн багцын 30 гаруй хувийг барилга, үл хөдлөх хөрөнгө, орон сууцны салбарын зээл эзэлдэг аж.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Улаанбаатар хотод 2012 онд 11.349, өнгөрсөн онд 19.390 айлын орон сууц тус тус ашиглалтад оржээ. Тэгвэл энэ онд нийслэлийн хэмжээнд урьдчилсан байдлаар нийт 20-25 мянган айлын орон сууц ашиглалтад орох Монголын барилгын үндэсний ассоциацийн тооцоо бий. Үүнээс гадна үл хөдлөх хөрөнгийн зах зээлд оруулах хөрөнгө оруулалт жил тутам 15-40 хувиар өснө гэсэн “Мастер пропертис” компанийн зах зээлийн судалгаа ч байгаа.

Одоогоор үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн гол төвлөрөл, хөгжил нийслэлд явагдаж байна. 2012-2020 онд үл хөдлөх хөрөнгийн эрчимтэй хөгжлийн суурь бүс Улаанбаатар байх юм. Түүнчлэн үл хөдлөх хөрөнгийн хамгийн том сан энд бий болох аж. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 219 барилгын төслийн 38.311 айлын шинэ орон сууц борлуулсан байна. Эдгээрийн 185 нь буюу 36.815 айлын энгийн орон сууц 34 буюу 1496 айлын хаусны зориулалттай сууц юм. Эдгээр төслөөс 50 хувь буюу 20 орчим мянган орон сууц бэлэн болоогүй. Энэ нь ирэх улиралд ашиглалтад орохоор төлөвлөгджээ.

Монголын санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг “Үл хөдлөх хөрөнгөд чиглэсэн гаднын хөрөнгө оруулалтыг татах. Мөн дотоодын барилгын компаниуд нэгдээд олон улсын санхүүгийн зах зээлд хувьцаа гаргаж, хямд эх үүсвэр бүхий хөрөнгө босгох боломжтой” гэв. Ингэснээр барилгын компаниуд арилжааны банкны богино хугацаат, өндөр хүүтэй зээлийн дарамтад орохгүй байх боломжтойг тайлбарласан юм.

Хэрэв дотоодын компаниуд өөрсдийн засаглалаа сайжруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг олохуйц зах зээлийн шаардлага хангасан байвал гаднын хөрөнгө татах нь илүү ашигтай болохыг Ө.Ганзориг хэллээ. Тэрбээр Азийн хөрөнгө оруулагчид өөрсдийн хөрөнгөө үл хөдлөх хөрөнгөд байршуулах сонирхол давамгай байгааг онцлов.

Монголын барилгын үндэсний ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаяр “Орон сууц худалдан авсан иргэн бүрт нэмүү өртгийн албан татвар /НӨАТ/-ын 10 хувийг төр бэлнээр буцаан олгож, байрны үнийг 10 хувь бодитоор буулгаж орон сууцжуулах бодлогоо татвараар дэмжье” гэсэн санал гаргасан. Түүний хэлснээр дээрх байдал биелэлээ олсон тохиолдолд татвараа бүрэн төлдөггүй барилгын компанид ашиггүй. Мөн хувиараа болон хулхи нэрээр туслан гүйцэтгэл хийдэг хэсэгт ч тэр. Үүнээс гадна хулгайгаар чанар муутай бараа оруулж ирдэг хувь хүн болон компани алдагдал хүлээх юм.

Үр дүнд нь орон сууц авсан иргэн хамгийн том хэрэглээндээ татваргүй болохын сацуу 10 хувьд хямд байртай болох боломжтой аж. Ингэснээр барилгын үйлдвэрлэл цэгцэрч, мэргэжлийн, тогтвортой, хариуцлагатай болж хөгжинө. Барилгын материалын чанар, хяналт эрс сайжирна. Хил гаалийн ачаалал буурч эргэлт хурдсаж үнэ буурна. Чанаргүй орон сууц цөөрнө. Салбарын шударга өрсөлдөөн бий болж үр ашиг дээшилнэ гэж Ц.Эрдэнэбаяр бас онцолсон. 2013-2016 онуудад барилгын салбарын бүтээн байгуулалт ихээхэн өсөлттэй байх хандлага ажиглагдаж байгааг Барилгын салбарын 2014 оны төлөв байдал” судалгаанд тэмдэглэжээ. Барилгын салбар муу нэрнээсээ салахаар ийн дор бүрнээ чармайж байна. Зах зээл тэднийг сориод эхэлчихэж. ■



Төв банкны “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд нийт 292.1 тэрбум төгрөгийн зээлийг банкуудаар дамжуулан барилгын компаниудад олгожээ



1сек Реклам

35.000-50.000₮ сурталчилгаа

тв шторк

мэргэжлийн түвшинд хийж байна.

Манай байгууллага нь
И-МЭЙЛ маркетингийн
ЦОГЦ
үйлчилгээг танд
санал болгож байна.

IKH KHARANGA





Web site
Mobile web
Mobile application

Бид таны болон танай байгууллагыг бүрэн илэрхийлэх
вэб, мобайлвэб, мобайл аппликашиныг
Мэргэжлийн өндөр түвшинд хурдан шуурхай хийж үйлчилнэ.

Харилцах утас: 9111-6586,9111-6588

ОНОЛ

ЭДИЙН ЗАСГИЙН УХААН ЮУГ СУДАЛДАГ ВЭ



Ц.БАТСҮХ
СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Энэ удаагийн буландаа эдийн засгийн ухаанаар юуг судалдаг талаар авч үзнэ. Эдийн засгийн ухаан нь дэлхийн улс орнуудын хөгжил болон нэг улсын доторх хүн амын амьжиргааны түвшин юуны учир ялгаатай байгаа. Мөн үйлдвэрлэгчид яагаад илүү ашиг, орлого олох бүтээгдэхүүнийг ихээр үйлдвэрлэхийг эрмэлздэг, бүтээгдэхүүнээс сонголт хийхэд хэрэглэгчид ямар хүчин зүйлс нөлөөлдөг болохыг ойлгоход тусалдаг.

Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хуваарилах, солилцох, хэрэглэхтэй холбоотой хүмүүсийн хооронд үүсч байгаа харилцааг эдийн засаг гэдэг. Хүний хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэгдсэн үнэ цэнэтэй зүйлс нь бүтээгдэхүүн (бараа, үйлчилгээ) юм. Хүмүүсийн хангагдаагүй хүсэл, шаардлагыг хэрэгцээ гэх бөгөөд энэ нь хязгааргүй их байдаг. Учир нь хүмүүс олон өрөтэй том байшин, цэцэрлэгт хүрээлэн бүхий эдлэн газар амьдарч, тансаг машин унаж, гоёмсог, ганган хувцас өмсөж, эрүүл хүнс, хоол хэрэглэн, бусдаас илүү боловсрол эзэмшихийг хүсдэг. Гэхдээ энэхүү хэрэгцээг хангах нөөц, бололцоо болох хөрөнгө, орлого нь хязгаарлагдмал шинжтэй. Уг зөрчилдөөнт байдал нь эдийн засгийн ухааны судлагдахууныг бий болгодог. Хүмүүс өөрийн бүх хүслээ гүйцэлдүүлэх боломжгүй шинжийг ховор хомс байдал гэдэг. Ховор хомс байдал нь бидэнд сонголт хийхийг тулгадаг.

Эдийн засгийн ухаан нь ховор, хомс байдлыг шийдэх хувь хүн, бизнес эрхлэгч, Засгийн газар, нийгмийн хийх сонголт, уг сонголтод нөлөөлж болох хөшүүрэг, хүчин зүйлсийг судалдаг нийгмийн шинжлэх ухаан юм. Эдийн засгийн ухааныг судалж буй асуудлын цар хүрээгээр нь микро болон макро эдийн засгийн ухаан гэж ангилдаг. Микро эдийн засгийн ухаан нь хувь хүн, бизнес эрхлэгчдийн хийж байгаа сонголт, уг сонголтуудын зах зээл дээрх харилцан үйлчлэл, түүнд нөлөөлөх Засгийн газрын нөлөөллийг, харин макро эдийн засгийн ухаан нь дэлхийн болон үндэсний эдийн засгийн хэмжээний асуудлуудыг судалдаг. Жишээлбэл, ямар нэгэн үйлдвэрийн газар бүтээгдэхүүнийхээ үнийг хэдээр тогтоох, тухайн нөхцөлд хэдэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудал нь микро эдийн засгийн судлагдахуун болдог бол ажилгүйдэл, инфляцийг бууруулах нь макро эдийн засагт хамаарагддаг.

Эдийн засгийн ухаан хэмээх шинжлэх ухааны салбар нь XVII-XVIII зууны заагт үүссэн гэж үздэг. Түүний хөгжилд “гүйлгээний хүрээнд баялаг өсч үрждэг” гэж үздэг меркантилист үзэл, “зөвхөн хөдөө аж ахуйн салбарт зарцуулагдаж байгаа хөдөлмөр л бүтээлч шинжтэй” хэмээн номлож байсан физиократ үзэл чухал үүрэг гүйцэтгэсэн. 1776 онд хэвлэгдсэн Адам Смитийн “Үндэстнүүдийн баялаг” хэмээх алдарт бүтээл эргэлт гаргасан гэдэг. Эдийн засаг гэх нэршил нь oikos (өрх гэр) ба nomos (хууль буюу дүрэм) гэсэн хоёр үгийн нэгдэл болох “Өрхийн аж ахуйг удирдах” гэсэн Грек үгнээс гаралтай.

Эдийн засгийн ухаан нь

• ямар бүтээгдэхүүнийг (юуг) хэнд зориулж, хэрхэн яаж үйлдвэрлэх вэ?

• хувийн болон нийгмийн сонирхолд нийцсэн сонголтыг хэзээ хийдэг вэ? гэсэн үндсэн хоёр асуултад хариулт өгдөг. Эхний асуулттай холбоотой ухагдахуунуудыг авч үзье. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бидний үйлдвэрлэж, хэрэглэж байгаа зүйлс өөрчлөгдсөөр байна. Тухайлбал одоогоос хорин жилийн өмнө гар утас, интернэтийг өнөөгийнх шиг өргөн хүрээнд хэрэглэдэггүй байсан. Иймээс бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч нар ирээдүйд хүмүүс юуг хэрэглэх вэ гэдгийг тооцоолж, үйлдвэрлэлээ эрхлэх хэрэгтэй болдог.

Бүтээгдэхүүнийг хэрхэн яаж үйлдвэрлэхийг тайлбарлахдаа эдийн засагчид үйлдвэрлэлийн хүчин зүйлс гэж нэрлэгдэх бүтээмжит нөөцүүдийг авч үздэг. Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг дөрөв ангилдаг. Үүнд:

- Газар
- Хөдөлмөр
- Капитал
- Үйлдвэрлэл эрхлэх ур чадвар багтдаг.

Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд оролцож буй хөрсөн дээрх болон доорх бүх төрлийн баялгийг газар, зарцуулж байгаа цаг хугацаа, хүмүүсийн биеийн болон оюуны хүчин чармайлтыг хөдөлмөр гэдэг. Газар нь аливаа үйлдвэрлэлийн анхдагч нөхцөл агаад, хэмжээг нь нэмэгдүүлэх боломжгүй өвөрмөц хүчин зүйл билээ. Хөдөлмөрийн чанар нь ажлын дадлага туршлага, сургалт, боловсролоор олж авдаг хүмүүсийн ур чадвар, мэдлэгээр тодорхойлогдох хүмүүн капиталаас хамаарна. Харин бүтээгдэхүүнийг



үйлдвэрлэхэд ашиглагддаг багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламж зэргийг капитал гэдэг. Үйлдвэрлэл эрхлэх ур чадвар нь үйлдвэрлэлийг зохион байгуулахтай холбоотой хүний нөөц юм. Хэнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх вэ гэдэг нь хүмүүсийн орлогоос хамаардаг. Үйлдвэрлэлийн дээрх хүчин зүйлсийг өрхүүд эзэмших ба газраасаа түрээсийн, хөдөлмөрөөс цалингийн, капиталаас хүү, ноогдол ашгийн, үйлдвэрлэх ур чадвараас урамшууллын орлого олдог.

Хоёр дахь асуултад хариулахтай холбоотойгоор дараах ойлголтуудыг мэдэх шаардлагатай болдог. Өдөр бүр хүмүүс юуг, яаж, хэнд зориулж үйлдвэрлэх вэ? гэдгээс хамааран эдийн засгийн сонголт хийж байдаг. Та хувийн сонирхолдоо нийцүүлж, өөрт хамгийн зөв гэж бодогдсон сонголтоо хийдэг. Нийгмийн ашиг сонирхолд хамгийн сайн нийцсэн сонголтыг нийгмийн сонирхол гэдэг. Хувь хүмүүс өөрийн хувийн сонирхолд нийцүүлэн сонголт хийж байхад эдгээр сонголт нь эргээд нийгмийн сонирхол болох уу гэдэг асуулт гардаг.

Эдийн засгийн шийдвэр гаргалт нь ховор хомс байдлаас үүдэлтэй. Үүний илрэл нь сонголт юм.Таны хийж буй сонголт бүр ацан сонголттой тулгардаг. Орлого, хөрөнгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, нэг зүйлийг авахын тулд өөр зүйлээс татгалзах шаардлагатай болдог. Үүнийг эдийн засгийн онолд ацан сонголт хэмээн нэрлэдэг.

Юуг гэсэн асуулт хүмүүс орлогоо хэрхэн зарцуулах, Засгийн газар татварын орлогоо хэрхэн хуваарилах, бизнес эрхлэгчид юуг үйлдвэрлэхээ сонгох үед, яаж гэсэн асуулт бизнес эрхлэгчид боломжит үйлдвэрлэлийн технологиуд дундаас сонголт хийхэд, хэн гэсэн асуулт нь хувь хүмүүсийн хооронд худалдан авах чадварын хуваарилалтыг өөрчлөхөд үүсдэг. Тухайлбал, Засгийн газар баян хүмүүсээс ядуучууд руу орлогыг хуваарилахад тэгш байдал ба үр ашгийн хооронд ацан сонголт хийхэд хүрдэг.

Ямар бүтээгдэхүүнийг хэрхэн, хэнд зориулж үйлдвэрлэх вэ гэдэг нь цаг хугацааны туршид өөрчлөгддөг. Бидний эдийн засгийн амьдралын чанарын сайжралттай холбоотой байдаг. Гэхдээ эдийн засгийн амьдралын чанар болон түвшин сайжрах эсэх нь сонголтуудаас хамаарна. Өнөөгийн хэрэглээ, чөлөөт цагаа эрхэмлэх эсвэл ирээдүйн үйлдвэрлэл, хэрэглээ, чөлөөт цагаа нэмэгдүүлэхийн хооронд бид гурван ацан сонголттой тулгардаг. Хэрэв бид хийхийг хадгалбал илүү их капитал худалдан авч, үйлдвэрлэлээ өсгөж чадна. Хэрэв бид чөлөөт цагаа багасгавал сурч боловсорч, өөрсдийгөө хөгжүүлж, илүү бүтээмжтэй болно. Хэрэв бизнес эрхлэгчид багыг үйлдвэрлэж, нөөцөө шинэ технологийг судлах, хөгжүүлэхэд зарцуулбал, тэд ирээдүйд ихийг үйлдвэрлэж чадна. Эдгээрээс хийсэн сонголт нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулж, түүний өсөлтийн хурдыг нэмэгдүүлдэг.

Ацан сонголттой холбоотой өөр нэг ухагдахуун үүсдэг нь алдагдсан боломжийн зардал юм. Ямар нэг сонголтыг хийхийн тулд татгалзсан хувилбаруудаас хамгийн үнэ цэнэтэй хувилбарыг сонгогдсон үйл ажиллагааны алдагдсан боломжийн зардал гэнэ. Хүмүүс өөрсдийн нөөцийг ашиглан, хийсэн зүйлсийнхээ нэмэгдүүлсэн өөрчлөлтийн үр дагаврыг тооцдог. Үйл ажиллагааны нэмэгдүүлсэн өсөлтийг даган бий болсон үр өгөөж нь түүний ахиу үр өгөөж, харин үйл ажиллагааны нэмэгдүүлсэн өсөлтийг даган бий болсон алдагдсан боломжийн зардал нь түүний ахиу зардал юм.Ямар ч үйл ажиллагааны хувьд хэрэв ахиу өгөөж нь ахиу зардлаасаа их бол хүмүүс тухайн үйл ажиллагааг нэмэгдүүлэх хөшүүрэг болно. Хэрэв ахиу зардал нь ахиу өгөөжөөсөө их бол хүмүүс тухайн үйл ажиллагааг багасгах хөшүүрэг болно. Хөшүүрэг нь тухайн үйл ажиллагааг урамшуулж байгаа шагнал, эсвэл түүнийг мохоож буй шийтгэл болно. Энэ нь нийгмийн сонирхол болон хувийн сонирхлыг давхцуулах гол түлхүүр юм.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ХООЛОНД НУУГДАХ ХОР

Х.ХУЛАН

Баярын ширээн дээрх төрөл бүрийн хоол унд, амттаныг харахад гоё байдаг. Яагаад? Эдгээр нь өдөр тутмын хоол хүнснээс өвөрмөц өнгө үзэмжээрээ хүнийг байлдан дагуулдаг. Үүний учрыг химийн салбар, хүнсний үйлдвэр хоёр чухам хамгийн сайн мэдэх аж. Учир нь тэд аль болох өнгө үзэмж сайтай, хүний анхаарлыг татахуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд нэгэн “шидэт” орц ашигладаг. Үүнийг та бараг гадарлаж байгаа биз. Тэр бол хүнсний будаг.

Бохь, чихэр, бялуу, мөхөөлдөс, чипс, тэр ч байтугай мах, махан бүтээгдэхүүн, дарсанд хүртэл хийдэг. Өнөөгийн байдлаар химийн аргаар нийлэгжүүлэн гаргаж авсан хүнсний нэмэлт 300-гаад бодис байдаг. Үүний талаас илүү хувь нь хүний биенд сөрөг нөлөөтэй тухай Дэлхийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагаас мэдэгдсэн байдаг. Нэмэлт бодисыг бүтээгдэхүүний өнгө үзэмжийг сайжруулах, тэжээллэг чанарыг алдагдуулахгүй байх, хадгалалтын хугацааг уртасгах, боловсруулалтын технологийн өртгийг хямдруулахын тулд хэрэглэдэг. Хүнсний будаг эдгээр бодисын нэг нь л юм.

Тухайлбал, Монгол Улсад 70 гаруй нэр төрлийн хүнсний нэмэлт хэрэглэж байна гэсэн судалгаа байдаг. Эл судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн 44 хувь нь БНХАУ-ын хүнсний будаг хэрэглэдэг гэжээ. Ихэнх хүнсний будаг эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлдэг. Ер нь хүнсний будаг орсон бүтээгдэхүүнээс татгалзаж сурвал Таны амь нас, эрүүл мэндэд өлзийтэй

Эдийн засагчид хүний төрөлхийн араншин нь байгалиас заяагдсан бөгөөд хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн төлөө байдаг гэж үздэг. Хувийн ашиг сонирхлоо дагасан үйлдэл нь хувиа хичээсэн үйлдэл байх албагүй. Хэрэв хүний төрөлх араншин нь байгалиас заяагдсан бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө байдаг бол хэрхэн нийгмийн ашиг сонирхлыг бий болгох вэ гэсэн асуулт гарна. Эдийн засагчид үүнд хариулахдаа нийгмийн сонирхлын төлөө ажиллах хөшүүргийг бий болгоход институцын үүрэг чухал хэмээн онцолдог. Хүмүүсийн хийж буй үйл хөдлөлийг хязгаарлаж байгаа дүрэм, журам, ёс заншил, дэгийг институц гэдэг. Институц нь албан ба албан бус гэж ангилагдах ба төр, байгууллага, холбоод, нийгэмлэг зэргээс гаргасан дүрэм, журам нь албан институц юм. Харин шашны хийгээд тухайн ард түмний ёс заншилтай холбоотой хязгаарлалтууд нь албан бус институц болдог. Тухайлбал, бидний шүтдэг шашны зарим зан үйл, номлол нь хүмүүсийн үйлдлийг хязгаарладаг. Хувийн өмчийг хамгаалах болон зах зээл дээрх сайн дурын солилцоог дэмжих хууль хувийн болон нийгмийн сонирхлыг нийцүүлэхэд гол үүрэгтэй.

Эдийн засагчид позитив болон норматив гэсэн хоёр үзэл баримтлалд хуваагддаг. Эдийн засгийн субьектүүдийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны өнөөгийн байдлыг баримтаар баталгаажуулан тайлбарлахыг шаарддаг эдийн засагчдыг позитив эдийн засагчид гэдэг. Дээрх зүйлсийг ийм тийм байх ёстой хэмээн норм, хэм хэмжээнд тулгуурлан авч үздэг тал нь норматив эдийн засагчид юм.

Эдийн засгийн үйл хөдлөл нь маш олон тооны хүчин зүйлээс шалтгаалдаг хүндрэл бэрхшээлээс ойлголтуудын хамаарал, нөлөөллийг хялбар тодорхойлох боломжгүй байдаг. Иймд “бусад зүйлс хэвээрээ байхад”(ceteris paribus) гэсэн таамаглалыг тавьж, бодит байдлыг хийсвэрлэн авч үздэг. Энэхүү хийсвэрлэл нь ойлголтын зарим төөрөгдөл, гажуудлыг үүсгэдэг талтай. Эдийн засгийн онол нь хүмүүсийн хийж буй сонголтууд, эдийн засгийн гүйцэтгэлийн талаарх бидний ойлголтыг нэгтгэн ерөнхийлсөн байдал юм.

Эдийн засгийн хүчин зүйлсийн өөрчлөлт нь тогтвортой бус байдгаас хоёр янзын төөрөгдөлд ордог. Нэгжийн хувьд биелэх чанар нь нийтэд биелэнэ эсвэл нийтийн хувьд биелэх чанар нь нэгжид биелэнэ гэсэн худал мэдээллийг бүрэлдэхүүний төөрөгдөл гэнэ. Нэг дэх үйл явц бий болсны учраас хоёр дахь нь бий болох ёстой гэсэн худал мэдээллийг учир шалтгааны төөрөгдөл гэдэг. ■

гэдгийг санаж явах хэрэгтэй болов уу.

Хүнсний будгийг олон төрлийн бүтээгдэхүүнд өргөн хэрэглэдэг. Хамгийн олон төрлийн хүнсэнд ордог хортой таван бодисын тухай хүргэе..

Е 102 Тартрацин (Аюултай)

• Шар азорын будагч бодис (Газрын тостой нийлэгжүүлж урвалд оруулан гаргаж авдаг анилин хэмээх бодисоос үүсэлтэй)

• Тартрацин нь удамшлын генд хортой нөлөө үзүүлнэ, харшил үүсгэнэ. Биеийн дархлааг сулруулна. 2010 оны долдугаар сарын 20-ноос тус бодисыг агуулсан бүтээгдэхүүн дээр “хүүхдийн анхаарал, идэвхийг бууруулна” гэсэн сануулга бичих болсон байна.

• Тартрацин дараах бүтээгдэхүүнд орсон байдаг: сироп, дэлбэрдэг чихэр, үнэр болон тусгай амт оруулсан бяслаг, мах орлуулагч бүтээгдэхүүн,



мөхөөлдөс, пудинг, царцаамаг, хоолны дараа иддэг амттан (десерт), архины төрлийн ундаа, жимсний дарс, гич, соус.

Е 104 Хинолин шар (Хортой)

• Хинолин шарыг төрөл бүрийн шар өнгө, цэнхэртэй нийлүүлж ногоон болгоход хэрэглэдэг.

• Е 104 бодисыг АНУ-д хэрэглэхийг хориглосон. Харшил үүсгэдэг. Хүүхдийн бие бялдрын хөгжилд муугаар нөлөөлдөг.

• Хинолин шар дараах бүтээгдэхүүнд орсон байдаг: сироп, дэлбэрдэг чихэр, үнэр болон тусгай амт оруулсан бяслаг, мах орлуулагч бүтээгдэхүүн, мөхөөлдөс, пудинг, хоолны дараа иддэг амттан (десерт), архины төрлийн ундаа, жимсний дарс, гич, соус, чихэр, жимсний чанамал.

Е 110 Шаргал (Хортой)

• Е 110 нь азорын будагч бодисын төрөлд багтдаг. Төрөл бүрийн шар, бор будаг гаргаж авдаг.

• Хулгана дээр хийсэн туршилтад амьтны мэдрэлийн тогтолцооны хэтийн үйл ажиллагаанд саатал учруулсан бодис. Түүнийг агуулсан бүтээгдэхүүн дээр “хүүхдийн анхаарал, идэвхийг бууруулна” гэсэн сануулга бичих болсон байна.

• Е 110 дараах бүтээгдэхүүнд орсон байдаг: яргай загас болон далайн хавч орлуулсан бүтээгдэхүүн, сироп, дэлбэрдэг чихэр, үнэр болон тусгай амт оруулсан бяслаг, мах орлуулагч бүтээгдэхүүн, мөхөөлдөс, пудинг, хоолны дараа иддэг амттан (десерт), архины төрлийн ундаа, жимсний дарс, гич, соус, чихэр, жимсний чанамал.

Е 122 Азурубин (Хортой)

• Улаан азорын төрөлд багтдаг. Тус бодисыг ягаан, бор өнгө гаргаж авахын тулд бусад бодисуудтай нийлэгжүүлдэг.

• Бүх төрлийн харшил үүсгэдэг. Амьтан дээрх туршилтаар уушги, нойр булчирхай, цусанд сөрөг нөлөө үзүүлсэн. Түүнийг агуулсан бүтээгдэхүүн дээр 2010 оноос “хүүхдийн анхаарал, идэвхийг бууруулна” гэсэн сануулга бичих болсон байна.

• Е 122 дараах бүтээгдэхүүнд орсон байдаг: шагшуур, яргай загас болон далайн хавч орлуулсан бүтээгдэхүүн, сироп, дэлбэрдэг чихэр, үнэр болон тусгай амт оруулсан бяслаг, мах орлуулагч бүтээгдэхүүн, мөхөөлдөс, пудинг, хоолны дараа иддэг амттан (десерт), архины төрлийн ундаа, жимсний дарс, гич, соус, чихэр, жимсний чанамал. ■

ЭРҮҮЛ МЭНД

ШИНЭЧЛЭГДЭХ ҮҮ...

С.ЗАЯА

Хамгийн хүнд сурталтай салбараар эрүүл мэндийнхэн тодорчээ. Өнгөрсөн онд бүх үйлчилгээний салбарт МҮХАҮТ-аас хийсэн судалгаагаар ийм дүн гарсан байна. Үндсэн хуульд хүн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй гэж заасан. Тиймээс эмнэлгийн үйлчилгээ Монгол Улсын иргэн бүрт хамааралтай. Тэр утгаараа улс төрөөс ангид томилгоо хийх ёстой салбар бол эрүүл мэнд. Энэ оны улсын төсөвт эрүүл мэндийн салбарт 570 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт суулгажээ. Үүн дээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 200 орчим тэрбум төгрөг нэмэгдэж байгаа аж. Өөрөөр хэлбэл, энэ жил тус салбарт 760-780 орчим тэрбум төгрөг зарцуулах юм. Энэ тоог ДНБ-тэй харьцуулахад 2.7 орчим хувь аж. Харин ДЭМБ аливаа улс ДНБ-ийхээ дор хаяж 7-9 хувьтай тэнцэхүйц санхүүжилтийг шийдэж байж эрүүл мэндийн салбараа авч явна гэсэн зөвлөмж гаргажээ. Манай улсын эрүүл мэндийн салбарын хөгжил хаана явна вэ. ДНБ-ийнхээ гурав хүрэхгүй хувийг зарцуулж буй хэр нь санхүүжилтийнхээ ихэнхээр худалдан авалт хийдэг байна. Үүнээс харахад, энэ салбарт хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах гол үүрэг доголдоход хүрсэн гэж хэлж болох. Вакцин хийлгэснээс болж, хариу урвал өгч биеийнх нь эд эс үхжиж буй тухай, тархинд нь харвалт өгсөн гээд энэ салбартай холбоотой сөрөг мэдээлэл хөвөрсөөр. Энэ зөвхөн сүүлийн нэг сарын дотор болсон явдлууд. Үүнээс өмнө төрөх эмнэлгүүдэд гарсан хариуцлагагүй үйлдэл, ГССҮТ-ийн даргын томилгооны хэрүүл, тангараг өргөсөн эмч нар ажил хаясан гээд тоочоод байвал олон. Эрүүл мэндийн салбар шинэчлэгдэх үү, цаашид ямар арга барилаар ажиллах ёстойг бид энэ удаа хөндөхийг зорилоо. Өвчин хэлж ирдэггүй. Ажилтай, орлоготой байхын тулд хүн бүр эрүүл байх ёстой. Тэр утгаараа эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж бидэнд маш чухал болчихоод байна.

Санхүүжилт тогтвортой байх нь чухал

Азийн хөгжлийн банк манай иргэдийн дунд байгаа ядуурлын гол шалтгааныг эрүүл мэндийн салбартай холбон судалжээ. Тэд тухайн хүний гэр бүлийнх нь гишүүдийн нэг нь гэнэтийн өвчин зовлон тусахад эмчлүүлэхийн тулд өөрт байгаа эд хогшлоо худалдаж буй нь ядуурлын нэг шалтгаан гэж үзсэн байна. Энэ судалгаа биднийг эмчилгээ оношилгооныхоо зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг тогтолцоо руу шилжүүлэх шаардлага буйг илтгэж байна. Манай одоогийн даатгалын систем ор, хоногоор санхүүждэг. Бусад улсад жилд нийт хүн амынх нь 3-8 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлдэг аж. Харин манайд энэ тоо 25-30 хувь. Учир нь ор хоногоор санхүүждэг учраас хэвтэх шаардлагагүй, өдрийн эмчилгээ хийлгэж болох хүмүүсийг хэвтүүлэн эмчилж, даатгалаас санхүүжилт авахыг боддог байна. Иргэн бүр хүссэн үедээ эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байх ёстой. Азийн хөгжлийн банкны дээрх судалгаанд тухайн иргэн эмчилгээ үйлчилгээнийхээ зардлын 60 хувийг өөрөөсөө гаргадаг гэжээ. Эрүүл мэндийн даатгалтай холбоотой энэ мэт асуудлыг нягтлах, эргэж харахыг дээрх судалгаа харуулж байна.

Үүнээс гадна энэ салбарт тулгамдаж буй томоохон зүйл нь дэд бүтцийн асуудал аж. 1990 оноос хойш стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилга огт баригдаагүй байна. Сүүлийн жилүүдэд хэд хэдэн томоохон эмнэлэг барихаар төсөв мөнгийг нь шийдсэн ч карказ босгохоос хэтрээгүй. Тухайлбал, нийслэлийн Хан-Уул дүүрэг Яармагийн дэнжид 300 ортой Эх хүүхдийн эрүүл мэндийн



үндэсний төв, нийслэлийн III төрөхийн барилга эхэлсэн ч нэг нь ч ашиглалтад ороогүй. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг зориулалтын дагуу баригдсан ч оффисын зориулалтаар ашиглана гэсэн маргаан дагуулаад буй. Түүнчлэн энэ салбарын санхүүжилт тогтворгүй байгаа нь эмнэлэг бие даан хөгжих боломж бүрдүүлэхгүй байна хэмээн мэргэжлийнхэн онцолж байсан.

Иргэдийн хэтэвчнээс гарах мөнгө багасна

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар даатгалыг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэхийн тулд Эрүүл мэндийн корпорацитай болохоор УИХ-ын чуулганаар ярилцаж байгаа. Уг корпораци эмнэлгүүдтэй гэрээ хийх замаар даатгуулагчийнхаа эрх ашгийг хамгаалах юм байна. Өөрөөр хэлбэл, тус салбарын өртөг зардал нь эрүүл мэндийн үйлчилгээнийхээ тарифаас хамаагүй өндөр гарчихаад буйг зохицуулах гэнэ. Энэ талаар Эрүүл мэндийн дэд сайд Ж.Амарсанаа “Өндөр үнэтэй эмчилгээний хэрэгслүүдийг даатгалд хамруулж эхэлсэн. Өмнө нь үе солилоо гэхэд үе солих материал нь тухайн хүнээс гардаг байв. Одоо иргэнээс гарах мөнгө багасна. Түүнээс гадна улсын болон хувийн эмнэлэгт даатгал үйлчилдэг болох юм. Өрсөлдөөн нэмэгдэхээр улсын эмнэлгүүдийн ачаалал эрс буурна. Эрүүл мэндийн салбарт сүүлийн жилүүдэд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүй. Маш олон тэрбум төгрөгийн техник шаардлагатай байна. Энэ санхүүжилтийг нэг жилийн төсвөөр хийх боломжгүй” гэв.

Ерөнхий сайдын багцаас өнгөрсөн онд 26 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж шинэчлэхэд зарцуулжээ. Эдгээр төхөөрөмж энэ оны хоёрдугаар улирал гэхэд бүрэн суурилагдаж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх аж. Мөн энэ ажлын хүрээнд компьютер томографын аппаратыг долоон аймагт суурилуулахаар болжээ. Харин улсын хэмжээнд дүрс оношилгооны аппарат улсын клиникийн нэгдүгээр эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвд л байдаг байна. Нарийн мэргэжлийн шинжилгээ хийлгэх хүн олон учраас уг аппаратын тоог нэмэгдүүлэх шаардлагатай аж. 2014 онд Эрүүл мэндийн яам ямар бодлого барьж ажиллах вэ. Энэ асуултад дэд сайд Ж.Амарсанаа “Энэ оныг бид Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарлалаа. Уг жилийн хүрээнд эхчүүдийг жирэмслэхээс нь өмнө эрүүлжүүлэх, жирэмсэлснийх нь дараа хяналтад сайн байлгах, төрөлтийн дараах тусламж үйлчилгээг чанаржуулах тал дээр онцгой анхаарч байна. Эрүүл мэндийн салбарт тодорхой хэмжээний ахиц дэвшил гарч байгаа. 2012 онтой харьцуулахад эхийн эндэгдэл өнгөрсөн жил зургаан хувиар буурсан нь бидний ололт” гэлээ.

Эрүүл мэндийн салбарт дээр дурдсан алдаа дутагдал, засч залруулах зүйл байна. Цаашид санхүүжилтийг нь ДНБ-ий ядаж таван хувьд хүргэж, ор хоногоор санхүүждэг тогтолцоог халах ёстой. Мөн дөрвөн жилд нэг удаа болдог сонгуулийн дүнгээс үл хамааран энэ салбарт ажиллаж буй нарийн мэргэжлийн бүрэлдэхүүнийг солихгүй байвал эрүүл мэндийн салбар манайд жинхэнэ утгаараа хөгжих гарц харагдаж байгааг эцэст нь тэмдэглэе.

ТЕХНОЛОГИ

ТӨГСГӨЛГҮЙ ӨРСӨЛДӨӨН

Б.БЯМБАДОРЖ

Apple компани 2007 оны нэгдүгээр сард хэрэглэгчдийн гар утасны ойлголтыг өөрчилсөн. Тэр нь iPhone хэмээх шинэ төрлийн ухаалаг гар утсыг танилцуулсан юм. Мөн оны арваннэгдүгээр сард Google компани Android гэх гар утасны үйлдлийн системийг танилцуулсан. Тэд гар утас үйлдвэрлэгчдэд үнэ төлбөргүй хэрэглүүлэхээр олон үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулжээ. Үүнээс хойш долоон жил өнгөрөв. Apple компани гар утасны зах зээлийг бүхэлд нь эзлэхэд саад болсон ганц зүйл нь Android үйлдлийн систем юм.

Энэхүү хоёр үйлдлийн систем зах зээлд давамгайлж байгаа нь учиртай. Тэд өндөр түвшний, чанартай системүүд болж хэрэглэгчдийн хэрэгцээг сайн хангаж чадсан. Харин энэ хоёрын аль нь илүү вэ? Сүүлийн хэдэн жилийн турш энэ асуултад хариулах гэж их маргасан. Үүний эцэст энэ асуултад шууд хариулах боломжгүй гэж дүгнэж байна. Android, iOS хоёр чанар сайтай үйлдлийн системүүд юм. Мэдээж хоёулаа давуу, сул талуудтай. Тиймээс ямар үйлдлийн системтэй гар утас худалдаж авах нь тухайн хүний сонголт л юм.

Тэд системээ яг ямар чиглэлээр зохиож байгааг ойлгохын тулд хоёр үйлдлийн системийн арга барилыг мэдэх хэрэгтэй.

Android нь хэрэглэгчдэд байж болох бүх эрх чөлөөг олгодгоороо онцлог. Харин iOS нь хэрэглэгчийн эндүүрэл, алдаанаас хамгаалж, утасны тогтвортой байдлыг хадгалахын тулд үйлдвэрээсээ маш олон хязгаарлалттай худалдаалагддаг байна. Хамгийн сүүлийн Android системийн хувилбар нь 4.4.2 KitKat нэртэй. Харин хамгийн сүүлийн iOS системийн хувилбар нь iOS 7 юм.

Төхөөрөмжүүд

Ямар ч гар утасны үйлдлийн систем сонгоход утасны төхөөрөмж нь өөрөө хамгийн чухал үүрэгтэй.

Google Android: Google компани үйлдлийн системээ олон нийтэд үнэгүй тараахаар шийдсэн. Тиймээс уг үйлдлийн системтэй гар утас маш олон бий. Тэдэнд HTC, LG, Sony, Samsung зэрэг үйлдвэрлэгчид багтана. Иймд Android үйлдлийн системтэй гар утаснууд олон төрлийн камер, хүчин чадал, дэлгэцийн хэмжээтэй байдаг. Мөн үнэ өртгийн хувьд ч өргөн сонголттой юм.

Apple iOS: Харин өрсөлдөгч нь зөвхөн Apple компанийн iPhone, iPod, iPad гэх тоотой хэдэн төхөөрөмж дээр худалдаалагддаг.

Сонголтын хувьд Google Android гар утаснууд илүү өргөн хүрээтэй. Мөн Apple төхөөрөмжүүдээс хямд үнэтэй байдаг. Иймээс сонголтыг эрхэмлэдэг хэрэглэгчид Android систем нь илүү боломжтой.

Тусгайлан өөрчлөх боломж

Ямар ч ухаалаг гар утсыг хувь хүний сонирхлын дагуу өөрчилж янзлах боломж нь тэр утсыг авах нэг гол шалтгаан болдог.

Google Android систем нь энэ хүрээнд үргэлж давуу байсаар ирсэн. Уг үйлдлийн системтэй ямар ч утсыг хүссэнээрээ өөрчилж болдог. Их “оролдвол” өрсөлдөгч iOS үйлдлийн систем ч суулгах боломжтой.

Android системийг бүтээгчдийн зүгээс хэрэглэгчдэд аль болох их хэмжээний эрх чөлөөг олгох бодлого баримталсаар ирсэн юм. Харин утсан дээр их хэмжээний өөрчлөлт хийх нь хожмоо сөрөг үр дүн үзүүлэх магадлалтай. Иймд Android хэрэглэгчид ийм үр дагавараас сайн сэргийлэх нь зүйтэй.

Apple iOS системийг ямар нэг байдлаар өөрчлөх боломжгүй. Хэрэглэгч байгаагаар нь хэрэглэх л боломжтой. Мөн мэдээлэл хуулах тохиолдолд iTunes гэх тусгай компьютерийн программ ашиглах шаардлагатай. Энэ нь зарим хүмүүст төвөгтэй санагдах нь бий. Иймээс ч iOS –ийн хэрэглээг хөнгөвчлөх зүйлсийг хүмүүс сэдсэн юм.

iOS системийг бүтээгчдийн хувьд ийм олон хязгаарлалт хийсний гол шалтгаан нь үйлдлийн системийн тогтвортой байдал. Түүнийг хэрэглэгчийн оролцоогүйгээр хангах явдал юм. Иймд iOS систем дээр ямар ч хэрэглэгч гацах асуудалтай учрахгүй. Гэсэн ч Android дээр байдаг олон сонирхолтой зүйлүүд хаалттай байх юм.

Ажил давхар хийх

“Multitasking” буюу олон ажил зэрэг хийх үйлдэл нь ухаалаг гар утасны давуу талуудын томоохон илрэл. Энд дээрх хоёр өрсөлдөгчийн хувьд бага зэрэг ялгаа байдаг нь сонголтод чухал үүрэг гүйцэтгэдэг.

Google Android нь олон үйлдэл зэрэг хийх үзүүлэлт дээр iOS системээс давуу байсаар ирсэн. Тухайлбал и-мэйлээ шалгах программаас өөр программ руу шилжих нь маш тухтай, шуурхай байдаг. Мөн бусад программууд үргэлж идэвхтэй байдаг нь тэдэн рүү хурдан хугацаанд шилжих боломж олгодог.

Үүний нэг сул тал нь утасны зайг хурдан дуусгадаг. Android хэрэглэгчиддээ аль болох түргэн шуурхай үйлчлэхийг эрхэмлэдэг. Гэхдээ утасны ажиллах хугацааг сайтар бодолцоогүй талтай.

Apple iOS нь хэдхэн сарын өмнө олон нийтэд түгсэн iOS 7 хувилбар хүртэл эдний төхөөрөмжүүд нь зэрэг ажил хийхэд харьцангуй чамлалттай байсан.

Энэхүү үйлдлийн системийг бүтээгчид хэрэглэгчийн оролцоогүйгээр бүх зүйлээ зохицуулдаг болгох зорилготой. Тиймээс хэрэглээнд байхгүй программуудыг автоматаар хаадаг. Мөн тэд олон үйлдэл зэрэг хийх дээр анхаарлаа бага хандуулж, програмуудыг хосолж хэрэглэх нь бага зэрэг хүндрэлтэй байжээ.

Программууд

Apps/applications буюу хэрэглээний программуудын хувьд энэхүү хоёр үйлдлийн систем томоохон онцлогуудтай. Энгийн жишээ дурьдахад Android үйдлийн системтэй утаснууд олон янзын интернет дэлгүүрээс программ авах боломжтой (Google Play-store, Amazon Appstore гэх мэт). Харин iOS нь зөвхөн Apple компаний App Store дэлгүүрээс л татаж авах боломжтой байдаг.

Google Android системийн нийт хэрэглээний программын тоо iOS системийнхээс бага. Харин үнэгүй программуудын тоо нь Apple Store –ийн үнэгүй программуудаас их юм.

Android үйлдлийн системтэй өргөн хүрээний төхөөрөмжүүд байдаг. Тийм болохоор ямар ч программ бүгдэд нь таардаггүй. Энэ асуудал нь програм зохиогчдод ч хүндрэл учруулдаг байна. Тэд ямар нэг программ зохиохдоо бүх Android хэрэглэгчдэд хүргэхийн тулд нэг программыг олон дахин бичих болдог.

Аль ч программ зохиогч өөрийн бүтээлээ ямар ч шалгуургүйгээр дэлгүүрт байршуулж, хэрэглэгчдэд шууд татаж авахад бэлэн болгох эрхтэй байдаг.

Apple iOS дэлгүүр нь хэдхэн төхөөрөмжид зориулсан юм. Энэ нь зохиогчдод амар байдаг. Мөн ямар нэг програмыг Apple Store дээр нийтлэх тохиолдолд тус компаний шалгах үзлэгт орж, сар гаруй хүлээх шаардлагатай. Иймээс тус дэлгүүрийн хэрэглээний программууд харьцангуй аюулгүй, найдвартай байдаг.

Ухаалаг утасны үе одоогоор дөнгөж цэцэглэж байгаа хэдий ч ирээдүйн хэрэглэгчид Android, iOS хоёр системийн нэгийг сонгох нь ойлгомжтой боллоо. ■




ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ

ЦАГААН+ХАР ТАВ+ХОЁР =хөгжил

Хятад улсын дундаж давхаргын иргэдийн тоо Англи улсын нийт хүн амаас дөрөв дахин их. “Руперт Хугверфийн 100 баяны жагсаалт”-ыг Хятадууд манлайлж Шянган мөн Тайванийн нэг тэрбумаас дээш хөрөнгөтэй баячуудын тоо Америкийг давжээ. Товчхондоо Хятад улс дэлхийд тэргүүлж байна. Үүний гол нууц нь Цагаан+хар 5+2=Хөгжил гэх хятад хүн бүрийн дагаж мөрддөг хөгжлийн философи юм. Цагаан дээр нэмэх нь хар буюу өдөр, шөнийг ялгалгүй хоногийн 24 цагт амралтгүй ажиллах. Тав дээр нэмэх нь хоёр ба ажлын таван өдөр амралтын хоёр өдөр зогсолтгүй ажиллах гэсэн утгатай. Уг филсофи нь Хятад улсын ажил хөдөлмөр эрхэлдэг хүн бүрийн уриа төдийгүй улсын хөгжлийнх нь цогц бодлого юм. Одоо БНХАУ-ын хүн ам ойролцоогоор 1.3 тэрбумд хүрсэн. Энэ хэрээр тус улсын эдийн засгийн өсөлт ажиллах хүчний асар том арми дээр тогтдог. 1980-аад онд Хятадын нэг хүнд ногдох ДНБ ердөө 200 ам.доллар байв. Одоо энэ тоо 6000-д хүрчээ. Мөн ядуурлын түвшин хурдацтай буурсан нь хүн бүр өдөр шөнөгүй ажилладаг. Түүнчлэн цаг ашиглалтыг хамгийн үр ашигтайгаар хөдөлмөрийн хуваарьт шилжүүлсний үр дүн гэдэг. Тэгвэл манай улсын хувьд хүн ам цөөн. Хэрвээ урд хөршийн хүн амын хэмжээнд хүрч ажиллах гэвэл Монголын хөдөлмөрийн насны нэг хүнд өдөрт дунджаар Хятадын 10 гаруй хүнтэй тэнцэх хэмжээний хөдөлмөрийн бүтээмжтэй байх шаардлагатай.

Долоо хоногийн нэг өдөрт хүн амын цалинтай ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, өдрийн нийт цагт эзлэх хувь




Гэхдээ


Дунджаар өдөрт ажлын найман цаг буюу 480 минут байдаг. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар Монгол Улсын дунджаар цалин хөлстэй ажил эрхлэхэд ажлын нэг өдөрт таван цаг буй 301 минутыг зарцуулдаг гэж байна. Энэ нь ажлын цагийн 62.7 хувьтай тэнцэж байгаа юм. Ер нь бол хангалтгүй үзүүлэлт. Юун нэг монгол хүн хятад 10 хүнтэй дүйцэх хэмжээний ажил хийх. Ажлынхаа найман цагийг ч үр бүтээлтэй өнгөрүүлж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдана.

Монголд ажилгүйдэл, ядуурал дорвитой буурахгүй л байна. Өнгөрсөн оны аравдугаар сарын мэдээллээр Улсын хэмжээнд 37.6 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байна. Гэхдээ бүртгүүлээгүй хэчнээн ажилгүй иргэн гэрийн мухар сахиж байгааг албан журмаар гаргасан тоо алга. Ямартай ч гурван монгол


Долоо хоногийн нэг өдөрт насанд хүрэгчдийн хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр (2011 он)



Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут хот, хөдөөгөөр (2011 он)



Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут хот хөдөөгөөр (2011 он)




Эх сурвалж: УСХ

хүн тутмын нэг нь ядуу амьдарч байгаа. Тэдний олонх нь ажил олдохгүй байна гэдэг ч үнэндээ бол ажил их байна аа, цаана чинь. Тухайлбал, манай улсад жилд дунджаар 40 гаруй мянган ажлын байрны захиалга Хөдөлмөрийн яам болон хөдөлмөрийн биржид ирдэг аж. Нөгөө талдаа жилд дунджаар 50 орчим мянган хүн ажил хайдаг гэх судалгаа байна. Гэтэл тэдгээр ажил хайж байгаа иргэдийн олонх нь ажилд гологдоод байдаг аж. Өдгөө ажил олгогчдын зүгээс “Ямар идэвх чармайлтгүй юм бэ”, “Монголчууд маань дэндүү бэлэнчлэх сэтгэлгээтэй”, “Өөрчлөгдөшгүй залхуу”. Ажил тасална, хоцорно, хатуу сархад хэтрүүлэн хэрэглэх гээд монголчууд ямар ч хөдөлмөрийн хүмүүжилгүй гэцгээж байна. Хэдийгээр бүх хүн тийм биш ч Статисткийн хорооны цаг ашиглалтын судалгаанаас харахад энэ зэмлэл оргүй биш ажээ. Улсын дунджаар эрэгтэй, эмэгтэйчүүд өдрийн нийт цагийн 3.1 хувь буюу 44 минутыг сурч боловсроход зарцуулдаг гэнэ. Хүмүүстэй харилцах, үзвэр үйлчилгээ зэрэг чөлөөт цагийн үйл ажиллагаандаа эрэгтэйчүүд өдрийн нийт цагийнхаа 5.7 хувь буюу 82 минутыг, эмэгтэйчүүд 4.2 хувь буюу 61 минутыг зарцуулдаг байна. Эрэгтэйчүүд ном, сонин унших интернетэд орох, телевиз үзэх зэрэг ажилд өдрийн нийт цагийн 124 минутыг зарцуулдаг. Эмэгтэйчүүд 107 минут зарцуулж иржээ. Мөн залуу идэр насныхан өдрийн нийт цагийн 50 орчим хувийг унтах, хооллох, ариун цэвэр сахих, өрийгөө эмчлэх зэрэг хувийн

хэрэгцээндээ зарцуулдаг байна. Эндээс дүгнэхэд залуучуудын олонх нь хувийн үйлсдээ цагаа зонхилон зарцуулж байгаа нь ажиглагдана. Гэтэл насанд хүрэгчдийн ажлын өдрийн цаг ашиглалтыг авч үзвэл, цалин хөлстэй ажилд эрэгтэйчүүд 397 минут эмэгтэйчүүд 281 минутыг зарцуулсан байна. Энэ нь манайх шиг ажиллах хүч багатай оронд гомдмоор үзүүлэлт юм.

Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн ажлын нэг өдөрт зарцуулсан дундаж минут, хүйсээр (2011 он)



Ялгаа

Өөрийгөө хөгжүүлэх болон хувьдаа зарцуулсан цагт боловсролын түвшингийн ялгаа ажиглагддаг аж. Тухайлбал, хүмүүстэй харилцах болон чөлөөт цагийн үйл ажиллагаа болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, интернэт ашиглахад зарцуулсан цаг боловсролын түвшин дээшлэх тутам нэмэгддэг гэнэ. Харин боловсрол бага хүн амын унтах, амрах, хооллох гэх зэрэгт зарцуулсан цаг бусдаасаа илүү байна. Мөн албан бус судалгаагаар оффисын ажилтнууд дунджаар 11 минут тутамд ажлаасаа өөр зүйлд анхаарал нь татагддаг аж. Тэр бүрт тухайн ажилтан эргэн хэвийн байдалдаа орохын тулд 25 минут зарцуулдаг гэнэ. Гэтэл өдгөө оффисын ажилтай хүмүүсийн ихэнх нь цахим орчинд 10 минут тутам ямар нэг үйлдэл хийдэг байна. ■

Долоо хоногийн нэг өдөрт хүн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин (улсын дундаж 2011 он)

	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын	Магистр/доктор
Боловсрол	17	89	61	55	5	4	10	1
Хүмүүстэй харилцах болон чөлөөт цагийн үйл ажиллагаа	67	84	69	66	66	66	69	78
Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглах	77	112	117	116	116	113	126	107
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	729	732	698	690	698	691	695	684

Долоо хоногийн нэг өдөрт хүн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин (Улаанбаатар хот 2011 он)

	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын	Магистр/доктор
Боловсрол	79	166	109	73	6	5	11	1
Хүмүүстэй харилцах болон чөлөөт цагийн үйл ажиллагаа	71	102	82	68	72	66	71	59
Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглах	133	145	140	124	125	121	130	111
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	791	767	714	702	709	693	696	685

Долоо хоногийн нэг өдөрт хүн өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг, боловсролын түвшин (хөдөө, орон нутаг 2011 он)

	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын	Магистр/доктор
Боловсрол	6	50	23	6	2	2	9	0
Хүмүүстэй харилцах болон чөлөөт цагийн үйл ажиллагаа	66	74	59	59	56	66	56	523
Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглах	66	95	98	95	102	94	105	16
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	717	715	685	658	681	686	688	671

Эх сурвалж: УСХ

COAL MONGOLIA 2014

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 4 ДЭХ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

МОНГОЛ УЛС 2014 ОНД 31,4 САЯ ТОНН НҮҮРС ЭКСПОРТОЛНО

Монгол Улсын нүүрсний геологийн таамаг нөөц 173.3 тэрбум тонн гэж тогтоосноос урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын дүнгээр 21.5 тэрбум нь баталгаажсан байдаг.

Баталгаажсан талбайд хийж буй олборлолтоос одоогийн байдлаар хамгийн томоохонд Тавантолгойн Баруун, Зүүн Цанхийн ордыг багтаан нэрлэдэг бөгөөд, 2013 оноос Баруун цанхийг эдийн засгийн эргэлтэд оруулснаар, тухайн тайлант онд нийт 1,9 сая тонн нүүрс олборлосноос, 1,1 саяыг экспортод гаргаж, 100 гаруй сая ам.долларын ашигтай ажилласан статистик мэдээлэл байна. Харин Зүүн Цанхиас 5 сая тонн нүүрс олборлосноос, 820 мянган тонн нүүрсийг экспортод гаргаад байна.

Санхүүгийн шинэ онд буюу 2014 онд Цанхийн Баруун, Зүүн хэсгээс нийтдээ 10 гаруй сая тонн нүүрс олборлох боломжтой гэдгийг судлаачид хэлж байна. Ингэснээрэнэ оны эхний улиралд гэхэд“Чалко” компанийн өрийг бүрэн төлж барагдуулна гэдгийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлагууд албан ёсоор мэдэгдээд байгаа.

Тавантолгой ийнхүү 2014 онд өрөө барагдуулснаар цаашид үйл ажиллагаа нь идэвхжиж, өөрийгөө бүрэн санхүүжүүлэх боломж бүрдэх юм. Цаашид нүүрс баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулж, нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэсэн таатай мэдээлэл ч дуулдаж байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дуулгаж буй сайн мэдээг Тавантолгойд үйл ажиллагаа явуулдаг өөр гурван компани буухиалж байгаа. Тэд Хятадын “Шинхуа Энержи” компанид 1 тэрбум тонн нүүрсийг 20 жилийн хугацаатай нийлүүлэхээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна. Хятадын Шинжлэх ухаан технологийн хүрээлэнгийн дэд захирал Зан Гуангжун ойрын жилүүдэд Монголоос жилд 30-50 сая тонн нүүрс импортолдог болно гэсэн албан мэдэгдэл хийсэн нь манай нүүрсний олборлолтыг дэмжих бас нэгэн сайн мэдээ гэдгийг онцлоход илүүдэхгүй.

2014 онд Монгол Улс 31.4 сая тонн нүүрс экспортлоно гэж Сангийн яамнаас тооцоолсон. Мөн Хятад улсруу



нүүрс экспортлох компаниудын тоо нэмэгдэх төлөвтэй гарч байна. Энэ нь манай улсын хар алт Хятад улсын төлөв байдалтай шууд хамааралтай байгааг харуулдаг. Гэхдээ ирэх онд дэлхийн төдийгүй Хятадын нүүрсний зах зээлийн төлөв өсөх хандлагатай байгаа нь ихээхэн анхаарал татаж байгаа юм. Түүнчлэн хар алтны ханш дийлэнх шинжээчдийн дүгнэлтээр ирэх онд өсөх төлөвтэй байгаа.

Тиймээс тоотой хэдхэн боловч тогтоон барьж үлдүүштэй эдгээр сайн мэдээ нь Монголын нүүрсний үнэ цэнийг 2014 онд дэлхийн зах зээлд өсгөх таатай боломж төдийгүй, цаашдын урт хугацааны тогтвортой байдал бүрдэх эхний алхам гэж ойлгож болохоор байна.

Шинжээчдийн таамаглаж буй 2014 онд нүүрсний зах зээл өсөлттэй байна гэх таамаглалтай энэ үед Монголын хамгийн том хурал болох “Coal Mongolia-2014” нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн хоёрдугаар сарын 20,21-ын өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна.

Хурлын дэлгэрэнгүй мэдээллийг 70115590 утсаар болон www.coalmongolia.mn, www.mining.mn сайтаас авах боломжтой. ■

Эх сурвалж: “Coal Mongolia-2014”

KHARANGA

Их харанга компанийн захиалгаар
Түрк улсад үйлдвэрлэсэн "Илч газ"
"Тор газ" компаний борлуулалтын
6-н цэгээс худалдан авааарай.

ИЛЧ БРЭНД

- Аялал зугаалга амралт зуслан ахуйн бүх хэрэгцээнд
- Хэрэглэхэд хялбар ашиглуй абсаархан
- Хүйтэний улирлын хамгийн найдвартай туслагч
- Дахин дахин цэнэглэж ашиглах зорилалттай
- 5 литрийн багтаамжтай



ИЛЧ GAZ

18-20цаг тасралтгүй асах хүчин чадалтай.

Газны үнэ 62'500₮
хошуу 15'000₮
дахин цэнэглэлт
5500₮





Газын нэмэлт хошуу
2 метр

Харилцах утас: 9666-7068, 9111-6586